**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
http://www.mmhi.gov.mn

2019.03.29 № 01/858

танай ____________-ны № ____________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар хэрэгжиж буй, Алт-2 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг яамны Удирдлагын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж зохих шийдвэрийг гаргасан болно.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 36 хуудастай.

Д.СУМЪЯАБАЗАР

08 0437

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 03 сарын 29 өдөр Дугаар 03. Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан;
2. Салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
3. Алт-2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
4. Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
5. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал, Н.Баатар нар хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Яамны 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланг хавсралтын хамт, салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 03 сарын 29 өдөр                Дугаар 03                Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан;
2. Салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
3. Алт-2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
4. Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
5. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал, Н.Баатар нар хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Яамны 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланг хавсралтын хамт, салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДАРГА                Г.НАНДИНЖАРГАЛ

# АЛТ 2 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2018 оны жилийн эцсийн байдлаар/

2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

**Нэг.** Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Алт-2" үндэсний хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр**. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг тус тус удирдлага болгон Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан "Алт-2" үндэсний хөтөлбөрийн явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийв.

**Гурав**. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 17 дугаар захирамжаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд ахалсан орон тооны бус зөвлөл байгуулагдсан. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Байгаль, орчин аялал, жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 6 төлөөлөл ажиллаж байна /хавсралт 1/.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Байгаль, орчин аялал, жуулчлалын сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2017.06.14-ний өдрийн А/66/202/А/174/А166 дугаар тушаалаар "Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг баталсан /хавсралт 2/. Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 49 үйл ажиллагааг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /46/, Ашигт малтмал, газрын тосны газар /46/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /19/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /18/, Сангийн яам /11/, Монгол банк /10/ зэрэг байгууллагууд 10-аас дээш 46 хүртэл үйл ажиллагааг толгойлон болон хамтран хэрэгжүүлнэ.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд хариуцан болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд нь 2017 онд 49, 2018 онд 49, 2019 онд 21, 2020 онд 20 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөнд 49 үйл ажиллагаа тусгагдсанаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 38 үйл ажиллагааг толгойлон, 46 үйл ажиллагааны хэрэгжилтэд хамтран оролцож, хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2018 оны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр 17 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 16 арга хэмжээ 70 хувь, 6 арга хэмжээ 40 хувь, 4 арга хэмжээ 0 хувиар тус тус дүгнэсэн.

Төлөвлөгөөний арга хэмжээний 3.1, 3.4, 4.4, 4.7-д заасан арга хэмжээний хувьд 2018 онд хэрэгжүүлсэн ажил тодорхой бус, биелэлт гаргаагүй тул 0 оноогоор үнэлэгдсэн.

“Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний нэгтгэл

| Зорилтын дугаар | Арга хэмжээ, үйл ажиллагааны тоо | | | Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ (хувь) | | | | | Хэрэгжилт (хувь) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ХАХ | ТАХ | ТҮА | 100 | 70 | 40 | 0 | ./-/ | |
| Зорилт 1 | 12 | 12 | 12 | 5 | 5 | 2 | 0 | 0 | 77,50 |
| Зорилт 2 | 5 | 5 | 5 | 2 | 2 | 1 | 0 | 0 | 76,00 |
| Зорилт 3 | 12 | 12 | 15 | 5 | 3 | 2 | 2 | 0 | 65.80 |
| Зорилт 4 | 8 | 8 | 11 | 1 | 4 | 1 | 2 | 0 | 52.50 |
| Зорилт 5 | 6 | 6 | 6 | 4 | 2 | 0 | 0 | 0 | 90.00 |
| **Нийт дүн** | **43** | **43** | **49** | **17** | **16** | **6** | **4** | **0** | **71.16** |

Тайлбар: З-хөтөлбөрийн зорилтын тоо, ХАХ-хөтөлбөрийн арга хэмжээний тоо, ТАХ-ерөнхий төлөвлөгөөний арга хэмжээний тоо,ТҮА-ерөнхий төлөвлөгөөний үйл ажиллагааны тоо, /-/-үнэлэх боломжгүй

“Алт-2” үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилт 77.5 хувь, 2 дугаар зорилт 76 хувь, 3 дугаар зорилт 65.8 хувь, 4 дүгээр зорилт 52.5 хувь, 5 дугаар зорилт 90 хувийн биелэлттэй буюу 2018 оны жилийн эцсийн байдлаар хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилт 71.16 хувиар дүгнэв.

**Дөрөв**. Дүгнэлт

1. Алт хөтөлбөрийн үр дүнд 2018 оны гүйцэтгэлээр хөтөлбөрийн үндсэн үзүүлэлтийн алт олборлолтын /20тонн/ төлөвлөгөөг 1.9 тн-р давуулан биелүүлж, Монголбанкинд тушаагдсан алтны хэмжээ 21.9 тн-д хүрсэн ололтой тал байна.
2. Хөтөлбөрийн хэрэгжилт нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 71.16 хувьтай үнэлэгдэв.
3. Төлөвлөгөөний арга хэмжээний

- 3.1. Алтны олборлох үйл ажиллагаанд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, байгаль орчинд ээлтэй тэргүүний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.4. Стратегийн ач холбогдол бүхий алтны ордуудын ашиглалтыг эхлүүлэх
- 4.4. Хууль бусаар алтны олборлолт явуулсан талбайн бүртгэл хийж, холбогдох этгээдийг тогтоох ажлыг улсын хэмжээгээр эрх бүхий төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах
- 4.7. Хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах гэж заасан арга хэмжээнүүдийн хувьд 2018 онд хэрэгжүүлсэн ажил тодорхой бус, биелэлт гаргаагүй тул 0,
- 4.3. Алтны орд ашигласны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн үнэлгээг тодорхойлох олон улсын туршлагыг судлан холбогдох аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх гэж заасан зорилтот ажлаа гүйцэтгээгүй,
- 5.3. Бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, нөхөрлөлийг чадавхижуулж бүртгэх замаар цаашид хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хүн амын орлогын болон бусад татвар, төлбөр, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох гэж заасан арга хэмжээний биелэлт төлөвлөгөөний заалттай авцалдаагүй байна.

4. “Алт-2” үндэсний хөтөлбөрийн

Зорилт-3. Алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник технологийг сайжруулж, шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх.,

Зорилт-4. Алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчинг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох үндсэн зорилтын хүрээнд хийгдэх бүтээгдэхүүн үй ажиллагааны хэрэгжилт удаашралтай, зарим хэрэгжүүлэх арга хэмжээ тасарсан байна.

**Тав**. Санал, зөвлөмж

1. “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөнд заасан арга хэмжээний биелэлт хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ, үйл ажиллагааг эрчимжүүлэхэд холбогдох байгууллага, газар нэгжүүд анхаарах
2. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг толгойлон хэрэгжүүлэгч байгууллага, ажил хариуцсан нэгжийн албан хаагчид ажлын уялдаа холбоог сайжруулах,
3. 2018 оноор дуусгавар болж байгаа үйл ажиллагааны хэрэгжилтийг бүрэн хангахад анхаарах
4. Төлөвлөлт хийхдээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, хэрэгжүүлэх байгууллагаас шалтгаалахгүй гадны хүчин зүйлийн улмаас хэрэгжилт тасарсан арга хэмжээнүүдийн талаар анхаарах

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү

Үнэлгээ хийж танилцуулга боловсруулсан:

Ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал

Мэргэжилтэн Д.Батнайрамдал /2019.03.22/

**2018 ОНЫ "АЛТ-2" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

| № | Хөтөлбөрийн агуулга | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1. | Засгийн газрын 2017 оны 1-р сарын 18-ны 20 дугаар тогтоолоор батлагдсан "Алт-2" үндэсний хөтөлбөр | **Хөтөлбөрийн зорилго** Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангах, татвар, хууль эрх зүйн орчинг тогтвортой байлгах, геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, Монгол улсын ашигт малтмалын сан хөмрөгийг арвижуулан баяжуулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг дээшлүүлэхэд оршино. |
| 2. | Санхүүжилтийн эх үүсвэр | Аж ахуйн нэгж, бичил уурхайчдын нөхөрлөлийн өөрийн хөрөнгө оруулалт; улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт; гадаад болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт; олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж; зээлийн эх үүсвэр; Монголбанк болон Хөгжлийн банкны эх үүсвэр. |
| 3. | Засгийн газар 2017-2020 оны 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага. УУХҮЯ, СЯ, БОАЖЯ, Монголбанк |
| | | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: АМГТГ, ҮХГ, СХЗГ, ЦЕГ, МХЕГ, Мэргэжлийн байгууллага, Мэргэжлийн төрийн бус байгууллага холбоодууд. Орон нутгийн захиргаа, алт олборлогч ААН |
| 4. | "Алт-2" үндэсний хөтөлбөрийн зорилтууд | Зорилт 1. Татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх<br>Зорилт 2. Геологийн судалгаа. эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулах<br>Зорилт 3. Алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник технологийг сайжруулж, шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх<br>Зорилт 4. Алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчинг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох<br>Зорилт 5. Бичил уурхайгаар алт олборлоход ашиглаж байгаа техникийн стандартыг боловсронгуй болгох, хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах болон борлуулах албан ёсны сүлжээ бий болгох |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Зардал | Төсөв (нийт шаардагдах зардал) 2018 он | 12750 сая төг | | | | | | | | |
| | | Үүнд: | Төлөвлөгөө | | | Гүйцэтгэл | | | Хувь | | |
| | | Улсын төсөв | 2017 | 2018 | нийт | 2017 | 2018 | нийт | | | |
| | | | 1500 | 2750 | 4250 | 1500 | 1206 | 2706 | | | |
| | | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | 250000 | 10000 | 260000 | 31940 | 22373 | 54313 | | | |

| | | |
|---|---|---|
| 6. | "Алт-2" үндэсний хөтөлбөрийн зорилт: | Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, татвар, хууль эрх зүйн таатай бүрдүүлэх, геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлж, алтны нөөцийг өсгөх, алт олборлох, боловсруул ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлж, олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэх, алт цэвэршүүлэх у байгуулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын ажиллагаанд хяналт, хариуцлагын тогтолцоог сайж бичил уурхай эрхлэлтийг боловсронгуй болгож албажуулах зорилтыг тавьж ажилласан. |
| | 1-р зорилтын хүрээнд: | 1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл |
| | **1.1 Алтны үйлдвэрлэлийн татварын орчин, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судалж, олон улсын чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх** | Уулын ажлын тайланд үндэслэн алт болон бусад салбарын татварын хувь хэмжээ, нийт зардал болон борлуулалтын орлогод эз хувь хэмжээг тогтоох замаар татварын ачааллын судалгааг шинэчилж гаргасан. ЭБМЗ-ийн хуралдаанаар 2010 оноос хойш хэлэл хүлээн авсан алтны ТЭЗҮ-үдийн үзүүлэлтийг ашиглан татварын ачаалалын судалгааг гүйцэтгэлээ. Тус судалгаанд нийт 170 алтны хамраггдсанаас шороон ордын 149, үндсэн ордын 21 төсөл хамрагдсан. Засгийн газрын ордонд УУХҮС-д 2018 оны 3-р са өдөр алтны салбарын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, алтны салбарын татварын эрх зүйн орчны талаар солилцсон. |
| | - Алтны татвар, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлах,<br>- Нөхцлүүдийг тодорхойлох<br>- татвар, санхүүгийн нэмэлт өөрчлөлт оруулах хууль, дүрэм, журмын санал бэлтгэх | АМГТГ-аас татварын багц хуулиудын шинэчлэлийн хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн төсөлд санал өгөхөөр холбогдох тооцоо судалгааг /алтны салбарын жишээн дээр/ хийж санал боловсруула оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 1/2593 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Энэ судалгаанд үнд боловсруулсан саналын тодорхой хэсэг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төсөлд тус одоогоор УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах шатанд явж байна. |

| | | |
|---|---|---|
| | - Саналыг шийдвэрийн төсөл болгон боловсруулах<br>- Шийдвэрийн төслийг холбогдох байгууллагаар уламжлуулан шийдвэрлүүлэх<br><br>Хүрэх үр дүн 1.1: /2017-2018/<br><br>Холбогдох хууль, эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | ЭБМЗ-ийн хуралдаанаар 2010 оноос хойш хэлэлцэгдэж хүлээн авсан алтны ТЭЗҮ-үүдийн үзүүлэлтийг ашиглан татварын ачааллын судалгааг гүйцэтгэлээ. Тус судалгаанд нийт 170 алтны төсөл хамрагдсанаас шороон ордын 149 , үндсэн ордын 21 төсөл хамрагдсан.<br><br>Алтны татварын эрх зүйн орчинг тогтвортой байлгах үүднээс Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, үзэл баримтлал, урьдчилсан тандан судалгааны хамтаар боловсруулж Засгийн газрын 2018 оны 10-р сарын 31-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. Хуулийн төсөл 2018 оны 12-р сарын 20-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн баригдсан боловч чуулганы ирц бүрэлдээгүй улмаас дараагийн хурал хуралдах хүртэл хойшлогдсон.<br><br>Биелэлт 90% |
| | **1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд орон нутгаас тавьдаг шаардлагыг хуулийн хүрээнд тодорхой болгох, алтны үйлдвэрлэлийн салбарын хүрээнд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй болгох.**<br><br>- Үйлчилгээг сайжруулах<br>-Нутгийн захиргааны байгууллагын оролцоо, шаардлагыг тодорхойлох,<br>- Байгаль орчин болон Мэргэжлийн хяналт, Ашигт малтмал, газрын тосны газрын оролцоо, шаардлага, үйлчилгээг тодорхойлох<br>- Төрийн байгууллагын хоорондын оролцоо, шаардлагыг тодорхойлох,<br>- Төрийн үйлчилгээний шуурхай байх зохистой хэлбэрийг тогтоох,<br>-Холбогдох хууль эрх зүйн үндэсийг бүрдүүлэх<br><br>Хүрэх үр дүн 1.2:/2017-2018/ | Алт хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд тус яамнаас АМГТГ-т 2017 оны 4-р сарын 5-ны 01/765 тоотоор салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ын уулын ажлын болон хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөө хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулж дуусгах, мөн нөөц нь тогтоогдсон боловч эдийн засгийн эргэлтэд орохгүй байгаа төслүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажилласны дүнд алт олборлогч ААН үйл ажиллагаа эрчимжиж олборлолтын хэмжээ өссөн байна. Алтны тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан болон төслийн орд ашиглах ТЭЗҮ-ийг хэлэлцэх хуралдааныг 2 сард нэг удаа хуралдаж байсныг нэмэгдүүлж сард 2-с доошгүй хуралдаж 2017 онд ЭБМЗ-н хурлаар нийт алтны хайгуулын ажлын үр дүнгийн 24 тайлан, алтны ордыг ашиглах нийт 37 төслийн ТЭЗҮ-г хүлээн авсан.<br><br>Засгийн газар огцорсонтой холбоотойгоор Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийг шинээр байгуулах хүртэл хугацаанд шинээр нөөц бүртгэх, ордыг ашиглах ТЭЗҮ-г хүлээн авах ажиллагаа түр хугацаагаар зогссон нь зарим хайгуул хийгдсэн талбайн төслийн үйл ажиллагааг эхлүүлэхэд цаг хугацаа алдахад хүргэж байсныг шийдвэрлэж шуурхай арга хэмжээг авч ажилласан.<br><br>УУХҮ-ийн сайдын 2018 оны 2 сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар "Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-д, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл/ЭБМЗ/"-ийн "Дүрэм аргачлал батлах" тухай УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 26-ны А/46 тоот тушаалаар тус тус дүрэмд холбогдох өөрчлөлт оруулж ЭБМЗ-ийг шинээр байгуулснаар ордын нөөцийг бүртгэж эхэлсэн. Тайлант хугацаанд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 15 удаагийн хуралдаанаар алтны 42 шороон орд, 5 алтны үндсэн ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайланг тус тус хэлэлцэж хүлээн авсан байна.<br><br>Биелэлт 70% |

| | | |
|---|---|---|
| | Төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй сайжруулсан байна. | |
| | **1.3 Алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журмыг шинэчлэн боловсруулж мөрдөх**<br><br>-Алт олборлох, баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх, худалдах журмыг шинэчлэн боловсруулах,<br><br>-Журмуудыг батлуулах,<br><br>- Батлагдсан журмуудын хэрэгжилтийг хангах<br><br>Хүрэх үр дүн 1.3: /2017-2018/<br>Журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлсэн байна. | “Алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, хүлээлцэх, тээвэрлэх худалдахтай холбогдсон жур төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулсан. Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу вэб сайтад байршуула нийтээс санал авсан. Мөн Сангийн яам болон Стандарт, хэмжил зүйн газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголын алт үйлдвэрлэ холбооноос албан ёсоор санал авч тусган зарим аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн саналыг төсөлд тусгасан.<br><br>АМГТГ-тай хамтран алтны чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, уул үеэр алтны салбарт тулгамдаад байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх нөхцөл боломжийн талаар санал солилцон боловсруулсан журмын төслийг танилцуулан хэлэлцүүлэг хийсэн. "Алт агуулсан хүдэр, элс олборлон баяжуулах, хамгаалах, ха тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журам"-ын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, хуульд заасн Нөлөөллийн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэж Хуулийн хэлтэст хүргүүлэн хянуулсан. Журмын төслийг яамны веб байршуулан олон нийтийн санал, зөвлөмжийг авч, улмаар Сангийн яам, Стандартчлал, хэмжил зүйн газар, Цагдаагийн ерөнхи Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооноос санал авч тусгасан. Мөн Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран алтны чи тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтын үеэр алтны салбарт тулгамдаад асуудал, тэдгээрийг шийдвэрлэх нөхцөл боломжийн талаар санал солилцон шинээр боловсруулсан журмын төслийг танил хэлэлцүүлэг хийж тэдгээрээс гарсан саналыг журмын төсөлд тусгасан. Журмын төслийг батлах тухай Уул уурхай, хүнд үйлд сайдын тушаалын төслийг боловсруулан Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлсэн. Журам батлах ту зүйн үндэслэл байхгүй учир Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус журмыг Геол уурхайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлах зохицуулалтыг тусгасан.<br><br>Биелэ |
| | **1.4 Алт олборлох болон баяжуулах, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах технологийн шаардлага, олборлолтын үеийн металл авалтын нормативт хязгаарыг тогтоож, холбогдох стандартыг боловсруулж мөрдүүлэх**<br>- Алтны олборлолтт болон баяжуулалт, боловсруулалтын технологийн шаардлагын судалгааг хийх,<br>- олборлолтын үеийн металл авалтын нормативт хязгаарыг тогтоох судалгааг хийх,<br>- Судалгаанд үндэслэн стандарт боловсруулах<br><br>Хүрэх үр дүн 1.4:/2017-2018/ | АМГТГ-аас УУХҮЯ-ны УУБГДарга Ж.Ганбаатарт техник, технологийн түвшиний үнэлгээний ажлыг алтны шороон ордын авалтыг дээшлүүлэх чиглэлээр судалгааны ажлын төслийн даалгавар, аргачлалыг боловсруулж цахим шуудангаар хүргүүлсэн.<br><br>Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын төсөлд алтны металл авалтын хувь, хэмжээг б талаар санал өгсөн.<br><br>Алт олборлолтын метал авалтын судалгаа боловсруулж хөтөлбөрийн хэрэгжилтэн тайланд тусгаж 2018 оны 1 дүгээр сары өдөр УУХҮЯ-д хүргүүлсэн. 2017 онд үйл ажиллагаа явуулсан 94 алт олборлогч аж ахуйн нэгжийн алтны метал авалт дунджаар ордод 91%, үндсэн ордод 86%-тай байна.<br><br>Судалгаанд үндэслэн стандарт боловсруулах ажил хийгдэж байна. Алт олборлогч аж ахуйн нэгжийн угаах төхөөр ажиллагааны металл авалтыг тодорхойлоход технологийн дээжлэлт хийгдэх бөгөөд энэ ажлыг хийхэд хүн хүч техникийн шаардлагатай тул санхүүгийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр металл авалтыг түвшинг тогтоож чадахгүй юм. |

| | | |
|---|---|---|
| | Холбогдох стандарт, журмыг боловсруулж мөрдүүлж эхэлнэ.<br><br>**1.5 Алтны зах зээл дэх эрэлт, хэрэгцээ, үнийн дунд хугацааны төсөөллийг тодорхойлох, алтны олборлолт, борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөх**<br><br>- Алтны зах зээлийн эрэлт, хэрэгцээ үнийн судалгаа, төсөөллийг урьдчилан гаргана<br><br>Судалгаанд суурилан алтны борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөх<br><br>Хүрэх үр дүн 1.5:/2017-2020/<br><br>Алт олборлолт, борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.<br><br>**1.6 Алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, алт олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, олборлосон алтыг худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор зээл олгох ажлыг хэрэгжүүлэх, тогтвортой хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх**<br><br>-Алт олборлогч аж ахуйн нэгжийн төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгааг нарийвчлан гаргана.<br>- Ойрын үед хэрэгжих боломжтой төслүүдийн жагсаалтыг гаргах | Биелэлт 60%<br><br>“Алт-2” үндэсний хөтөлбөрийн дор санаачилж зохион байгуулсан “Монгол Алт” аяны хүрээнд Монголбанкны Судалгаа статискийн газраас 2017 оны 8-р сард Алтны зах зээлийн төлөв, дунд хугацааны чиг хандлагын судалгааны ажлыг хийж, 2016-2020 оны алтны үнийн таамаг, алтны олборлолтын төлөв, алтны экспортын оновчтой төлөвлөлтийн байдлыг хамруулсан байна. Мөн АМГТГ-аас дунд хугацааны алт олборлолт, үнийн судалгааны статистик мэдээллийн судалгааг хийсэн.<br><br>Алтны үнийн судалгааг нэгтгэж сар бүр АМГТГ-ын цахим хуудсаар дамжуулж нийтэд мэдээллэсэн. Алтны үнийн хэтийн төлөв боловсруулж Алт-2 хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд тусгаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br><br>Биелэлт 100%<br><br>Алтны салбарт олгох санхүүгийн дэмжлэг олгож байсан өмнөх сайн туршлагуудыг судлах, боломжит хэлбэрүүдийн талаар санал боловсруулсан. “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд алт олборлогч компаниудад хөнгөлөлттэй зээл олгох асуудал тавигдсан бөгөөд 2017 оны 2-р сарын 24-ний УУХҮ-ийн сайдын А/42 тоот тушаалаар Сангийн яамны ТНБД-аар ахлуулсан “Санхүүжилт хариуцсан салбар зөвлөл”-ийг байгуулан алт олборлогч ААН-дэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, алт олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, олборлосон алтыг худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор зээл олгох ажлыг эхлүүлэх үүрэг өгөгдсөн. Алтны санхүүжилтийн асуудлаар Сангийн яам, Монголбанкны салбар зөвлөлийн холбогдох хүмүүс, алт олборлогч томоохон 25 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулсан уулзалтыг 3-р сарын 22-нд УУХҮЯ-нд зохион байгуулсан. Санхүүжилт хариуцсан салбар зөвлөлийн хуралдаанаар санхүүгийн боломжит хувилбаруудыг боловсруулан судалж үзсэний үндсэн дээр уг хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж, тус банкинд санхүүжилтийн эх үүсвэр дутсан тохиолдолд Засгийн газрын тусгай сангийн хуульд нийцүүлэн Төсвийн тогтворжуулалтын сангаас богино хугацаатай эх үүсвэр байршуулж байхаар шийдвэрлэсэн. Үүний дагуу Сангийн сайдын 2017 оны 131 дүгээр тушаал батлагдан, 2017 оны 5-р сарын 4-ний өдрийн 44/2/224 дугаартай “Эх үүсвэр байршуулах гэрээ”, 2017 оны 5-р сарын 31-ний өдрийн 59 дугаартай “Эх үүсвэр байршуулах гэрээ”-г Хөгжлийн банктай байгуулан, эдгээр гэрээний хүрээнд нийт 68 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тус банкинд байршуулж ажилласан. Уг эх үүсвэрийг 2017 оны 12-р сарын 25-ны өдөр эргэн төлөгдөхөөр байршуулсан болно. Санхүүжилт шаардлагатай алтны 130 төслийн жагсаалтыг гаргаж Хөгжлийн банкинд хүргүүлсэн. 2017 оны 11-р сарын 15-нд “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд алтны төслүүдийг санхүүжүүлэх боломжийн талаар “Онц шийдэл” ХХК-ний хүсэлтийн дагуу Алт үйлдвэрлэгчдийн холбооны төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж хамтран ажиллахаар санал солилцов. |

| | | |
|---|---|---|
| | - Дунд хугацаанд хэрэгжих боломжтой төслүүдийн жагсаалыг гаргах<br><br>Хүрэх үр дүн 1.6:/2017-2020/<br><br>Алт олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, олборлосон алтыг худалдан авах нөхцлөөр зээл олгох ажлыг хэрэгжүүлсэн байна.<br><br>**1.7 Алтны олборлолтын ажил төвлөрөн явагдаж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт бүхий бүсийг тогтоон алтны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг иж бүрэн цогцоор нь хэрэгжүүлэх**<br><br>Алтны олборлолтыг дэмжих зорилгоор тусгай зориулалттай талбайн бүсийн судалгааг хийх<br><br>- Тусгай талбайг алт олборлолт төвлөрсөн Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Дорнод, Увс аймгийн нутгийн 5 бүсэд байгуулах<br><br>- Эдгээр онцгой талбайд орон нутаг, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны хамгаалал, уурхайн хаалт, Монголбанк, Үнэт металлын сорьцын хяналтын газрын салбар, харуул хамгаалалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.<br><br>- Алт олборлолтыг нэмэгдүүлэх нөөц өсгөх, судалгааг гаргаж, хэрэгжүүлэх<br><br>Алт олборлолтыг нэмэгдүүлэх, нөөц өсгөх, нөөцийг бүрэн хаягдалгүй ашиглах, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг сайжруулах | Хөгжлийн банк зээллэг хүссэн 25 ААН-ийг судалж, материалаа бүрэн бүрдүүлж шаардлага хангасан алт олборлогч 13 ААН-/ тэрбум төгрөг олгохоор шийдвэрлэснээс 2017 онд 10 ААН-д 31,9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоны дунд, тэдгээр н ажиллагаагаа явуулж алт олборлолтоо эхлүүсэн бөгөөд 114,4 кг алт олборлосон байна.<br><br>Хөгжлийн банк, Монголбанкны удирдлагуудтай алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар уулз зохион байгуулж санал солилцсон. "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2018 оны 11-р сарын 30-ны өдрийн бай/ нийтдээ алтны 26 төсөлд 53.273 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд нэмж 43.821 тэрбум төгрөг олгох үлдэгдэлтэй бай<br><br>Биелэл<br><br>Алтны олборлолтыг дэмжих зорилгоор тусгай зориулалттай талбайн бүсийн судалгааг Заамарын, Сэлэнгийн нутаг дэв хүрээнд хийж хил заагийг тогтоон Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн яамдаас санал авч Засгийн газрын хуралд хэлэлцүүлэхээр бэлдсэн. Сэлэнгэ аймгаас ирүүлсэн орон нутгийн саналыг АМГТГ-т хүргүүлэн шийдвэрлэх боломжтой эсэхийг няг<br><br>Хойд Хэнтийн алтны металлогены бүсэд хамаарах Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган аймгуудыг хамарсан буюу Сэлэнгэ а Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол сумд, Дархан-Уул аймгийн Орхон туул сумын нутаг дэвсгэрийг судлан нэгдсэн зохион байгуулал бүсийн хил заагийг тогтоон хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилтыг хэрэгжүүлэн ажилласан. ЗГХ Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Дорнод, Увс аймгуудын Засаг даргын Тамгын газар, БОАЖГ, МХГазар, Татварын хэлтэстэй хамтран нөөц өсгөх хайгуул хийх бүс нутгийг сонгон ИТХ-аар хэлэлцүүлэн тогтоох зөвлөмж өгсөн.<br><br>2017 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар алтны ашиглалтын 19 тусгай зөвшөөрөл олгогдож, алтны 24 ордын хайгуулын аж үр дүнгийн тайлан, ордыг ашиглах 37 төслийн ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж баталсан байна. 2017 онд улсын хэмжэ алт олборлолтын хэмжээ урд жилийнхээс 2 тн-р нэмэгдэж, Монголбанкин дах алт тушаалтын хэмжээ 20 тн-д хүрсэн бол 2018 он, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 15 удаагийн хуралдаанаар алтны 42 шороон орд, 5 алтны үндсэн ордын хайгуулын ажль дүнгийн тайланг тус тус хэлэлцэж, нийт 23.2 тн алтны нөөцийг хүлээн авсан байна байна.<br><br>"Алт-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд алт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас санаачлан Монгол Улсын хэ "Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа" аяныг 5 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж алт тушаалтын хэмжээг 1.9 нэмэгдүүлж 2018 онд 21,9 тн олборлосон үзүүлэлттэй байна. Энэ ажлын хүрээнд Дархан-Уул, Баянхонгор аймагт алт худалда сорьц тогтоох нэг цэгийн төв байгуулагдаж орон нутагт алтыг худалдаж авч эхэлснээр Улаанбаатар хот дахь сорьцын лабора төвлөрлийн ачааллыг бууруулахын зэрэгцээ тухайн орон нутагт алт тушаагчдад зардал, цаг хугацаа хэмнэх боломжийг бүрдүүлж<br><br>Орон нутгийн хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийлгэхтэй холбоотой үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх Ажлын хэсгийг Ү ын 2018 оны 5 дугаар сарын 1-ний А-90 дугаар тушаалаар байгуулж ажилласан. Ажлын хэсгээс алт олборлолт явагдаж буй Төв, С Баянхонгор, Өвөрхангай аймгийн нутагт ажиллаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал дүгнэлтийг гарган удирдлагуудад танилцуулсан. |

| | | |
|---|---|---|
| | Хүрэх үр дүн 1.7:/2017-2018/<br><br>Алт олборлолтын хэмжээг жилд 2 тн-с багагүй хэмжээгээр нэмэгдүүлнэ. Төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулна.<br><br>**1.8 Хууль бусаар алт олборлохыг таслан зогсоохтой холбоотой эрх зүйн орчинг сайжруулах**<br><br>-"Ашигт малтмалын тухай" хууль, Уул уурхайн тухай хуулинд тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй болох нь уулын ажлын болон хайгуулын ажлын тайлан төлөвлөгөөгөөр тогтоогдсоныг үндэслэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох чиглэлээр тусгах<br><br>-Аймаг, сумын Засаг дарга болон хууль бусаар ашигт малтмал олборлогч этгээдэд ноогдох хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох<br><br>-Хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа эрхлэгчдийн талаархи судалгааг нутаг дэвсгэрийн тархалт, ашиг орлого, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хийж тоог бууруулах<br><br>Хүрэх үр дүн 1.8:/2017-2018/<br><br>Хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо буурсан байна. | Биелэлт 100%<br><br>Сэлэнгэ, Төв аймгийн нутагт алт олборлогч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нөхөн сэргээлтийн байдалд БОАЖЯ, УУХҮЯ, АМГТГ, ЦЕГ, орон нутгийн мэргэжлийн хяналтын газар, тухайн орон нутгийн захиргаанаас нэгдсэн шалгалтыг хийж газар дээр нь очиж танилцан голыг бохирдуулж байгаа шалтгаан цаашид авах арга хэмжээний талаар нэгдсэн хурлыг зохион байгуулав. Сэлэнгэ аймгийн хувьд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг түүний дотор хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг нь иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирдэггүй, харин цагдаагийн байгууллага, МХГ, БОАЖГ зэрэг байгууллагын хяналт шалгалтын ажлын үр дүнгээр илэрч байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд хууль бусаар ашигт малтмал олборлож хайсан Ерөө суманд 34, Бугант тосгонд 24, Хүдэр суманд 26, Мандал суманд 9, Баянгол суманд 7, Орхонтуул суманд 9 тус тус зөрчлийг бүртгэж шалгасан байна.<br>Дархан-Уул аймагт ЗДТГ-аас 12 удаагийн хяналт шалгалтын ажлыг явуулж, хууль бусаар алт олборлохыг завдсан болон олборлосон болох 4 ААН, 9 иргэнд хамаарах 12 удаагийн хууль бус үйлдлийг илрүүлэн, хуулийн дагуу арга хэмжээг авахуулж ажилласан байна.<br>Монголбанкнаас санаачилж байгаа "Алт-2" хөтөлбөр болон "Монгол алт" аяны хүрээнд алт тушаалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран үйл ажиллагаа явуулж, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвд "Монгол Алт" төрийн байгууллагуудын хамтарсан өдөрлөгийг 2017 оны 10-р сарын 12-нд амжилттай зохион байгуулж "Алт-2" хөтөлбөрийн хэрэгжилт, алт нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, алтны хууль бус ажиллагааг бууруулах талаар хэлэлцүүлэг хийгдсэн.<br><br>Хууль бусаар олборлолт явуулсан талбайн мэдээллийн судалгааг орон нутгаас авч нэгтгэсэн. Мөн цагдаагийн байгууллагаас холбогдох мэдээллийг авч ажилласан. Хууль бус алт олборлолттой тэмцэх чиглэлээр 2018 оны 7-р сард УУХҮЯ-ны ТНБД-р ахлуулсан ЦЕГ, МХЕГ, АМГТГ-ын бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийн баг Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Сэлэнгэ, Төв, Булган аймгийн нутагт очиж хувиараа болон хууль бусаар алт олборлож байгаа 60 гаруй иргэд, 90 орчим нөхөн сэргээлт явуулахаар эрх авсан аж нэгжийн үйл ажиллагаанд нэгдсэн шалгалтыг явуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан<br>Бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, хувиараа ашигт малтмал олборлох хууль бус үйл ажиллагааг бичил уурхайн зохион байгуулалтад оруулах, албажуулах, байгаль орчны хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 13 аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажилласан.<br><br>Орхон голын урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн буруутай үйл ажиллагаанаас голын ай сав газарт иргэд оршин суух, мал бэлчээрлэх боломжгүй болж байгаа тухай Ерөнхий сайдыг Өвөрхангай аймагт ажиллах үед иргэдээс гарсан гомдлын дагуу Орхон голын сав дагуух ашиглалтын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан.<br><br>ЕТГ, АМГТГ, АТГ, ЦЕГ, МХЕГ, аймгийн МХГ, Прокурорын газартай хамтран 2018 оны 10.23-11.06-ны хооронд Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Өвөрхангай зэрэг аймгуудад уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААН-дэд хяналт шалгалт хийхэд 32 ААН хамрагдсан байна.<br><br>Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд БОАЖ-ын дэд сайд Ц.Батбаяр 2018 оны 9-р сарын 5-нд "Ашигт малтмалын хууль бус олборлолт, түүнийг таслан зогсоох чиглэлээр авах арга хэмжээ" гэсэн танилцуулгыг хийж энэ чиглэлээр АХ байгуулан ажиллаж байна. |

| | | |
|---|---|---|
| | | АМГТГ-т БОАЖЯ-наас 2018.07.20-ны 03/5092,5093 тоотоор "Хурай"ХХК-ний MV-000201, "Эко алтан Заамар"ХХК-ний MV-0011 тоот дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох дүгнэлтийг хүргүүлсэн.<br><br>Биелэ |
| | **1.9 Зэс болон бусад металлын баяжмал дахь үнэт металлыг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг татварын болон хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих**<br><br>-Алт, зэс бусад металлын баяжмал дахь үнэт металл ялган авах боломжийн судалгаар боловсруулна.<br><br>-Баяжмал үйлдвэрлэн гаргаж байгаа аж ахуйн нэгжүүдийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулахад дэмжлэг үзүүлэх<br><br>Хүрэх үр дүн 1.9:/2017-2020/<br><br>Алт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулах нөхцлийг бүрдүүлсэн байна. | Зэсийн баяжмал дах үнэт металл болон бусад дагалдах эрдсийг гүн боловсруулан ялган авч, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор шийдвэр гарч зэс хайлуулах үйлд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барихаар төлөвлөж төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх судалгааны ажлыг эхл Ингэснээр цаашид Оюутолгой, Эрдэнэт, Цагаан суварга зэрэг ордын зэсийн баяжмалын түүхий эдээс алт ялган авах урьдчилсан бүрдэнэ.<br><br>Оюутолгойн үйлдвэрийн районд байрлах Азиагоулд Монголиа ХХК-ийн эзэмшлийн XV-014455 хайгуулын тусгай зөвшөөрлийн т хил хязгаарт үйлдвэрийн байршлын талбайг урьдчилсан байдлаар сонгож талбайд хийгдсэн геологи хайгуулын ажлын жил бүрий оноос хойших) тайланг судлан үзэж дүгнэлт гаргасан. Дээрхи дүгнэлтийг үндэслэн XV-014455 хайгуулын тусгай зөвшөөрлийн т хил хязгаар доторх үйлдвэр барихад зориулагдсан талбайг хэсэгчлэн буцаах асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг "Зэсийн ба боловсруулах үйлдвэр"-ийн төслийн нэгжээс 2018.02.07-ний өдрийн 02/008 дугаар албан бичгээр АМГТГ-т хүргүүлсэн. Мөн Ази Монголиа ХХК-д газрын асуудлыг шийдвэрлэх талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах хүсэлтийг Төслийн нэгжээс 2018.0 өдрийн 02/009 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Одоогийн байдлаар АМГТГ-ын даргын 2018.03.05-ны өдрийн 1/2071 дугаар бичгээр хариу ирүүлээд байна.<br><br>Монгол Улсад Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах санал зөвлөмжийг Уул уурхайн Мэргэжлийн холбоодын зөвлөлөөс боловср бөгөөд Алт цэвэршүүлэх үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br><br>Биелэ<br><br>Хугацаа бо |
| | **1.10 "Алтны бирж" байгуулах боломжийг судлан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх**<br><br>- Алтны бирж байгуулах судалгааг хийнэ.<br><br>- Судалгааг үндэслэн санал дүгнэлтийг гарган, холбогдох журмын төслийг боловсруулна. | Алтны ханшийн эрсдлээс хэрхэн хамгаалах Монголын форекс брокерын "Mgl forex financial services" ХХК байгуулагд ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэ байгууллагын хувьд алтны биржийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах техникийн урьд нөхцлийг бүрдүүлэх боломжтой болсон байна.. |

| | | |
|---|---|---|
| | Хүрэх үр дүн 1.10:/2017-2020/<br><br>“Алтны бирж” байгуулах боломжийг судлан хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.<br><br>**1.11 Алтыг орон нутагт худалдан авах үйл ажиллагааг Монголбанкны салбар буюу арилжааны банкаар гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх**<br><br>-Алтыг орон нутагт худалдан авах үйл ажиллагааг судлан судалгааг гаргана.<br><br>- Судалгааг үндэслэж алт худалдан авах үйл ажиллагааг эхлүүлэх<br><br>Хүрэх үр дүн 1.11:/2017-2020/<br><br>Судалгааг гаргасан байна<br><br>**1.12 Бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх болон сорьц тогтоох үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмыг шинээр боловсруулан мөрдүүлэх**<br><br>-Бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх болон сорьц тогтоох журмын судалгааг боловсруулна<br><br>- Судалгаанд суурилсан холбогдох журмыг шинээр боловсруулна<br><br>Хүрэх үр дүн 1.11:/2017-2020/ | Биелэлт 30 %<br><br>Хугацаа болоогүй<br><br>“Алт-2” үндэсний хөтөлбөрт тусгагдсан энэхүү зорилтын дагуу “Лаборатори байгуулах тухай” Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 275 дугаар тогтоол, “Орон нутагт алт худалдан авах үйл ажиллагааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А-108 дугаар тушаал батлагдан гарч Дархан-Уул аймагт 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Баянхонгор аймагт 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр алтны сорьц тогтоох худалдан авах нэг цэгийн төвийг нээн алт худалдан авах ажлыг орон нутагт эхлүүлснээр тус салбаруудад 2018 онд 222 кг алтыг хүлээн аваад байна.<br><br>Биелэлт 100%<br><br>Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 9 дүгээр сарын 3-ны А-226 дугаар тушаалаар Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журамд орон нутагт (үнэт металл) алтан гулдмай худалдан авах, худалдах, түр хугацаагаар хадгалах, тээвэрлэх хэсэгт өөрчлөлт оруулсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Н-31 дүгээр тушаалаар Орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбараас Эрдэнэсийн санд үнэт металлыг тээвэрлэхэд бэлтгэх, тээвэрлэх журмыг батлуулан мөрдөн ажиллаж байна. Дархан-Уул, Баянхонгор аймаг дахь Монголбанкны хэлтэс, салбар иргэн, аж ахуйн нэгж, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авч байна.<br><br>Биелэлт 70%<br><br>Хугацаа болоогүй |

| | | |
|---|---|---|
| | Журмын төслийг боловсруулсан байна | |
| | 2-р зорилтын хүрээнд:<br><br>2.1 **Алтны хэтийн төлөв бүхий бүс, нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн болон алтны сэдэвчилсэн судалгаа, ерөнхий эрлийн ажлыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилийн улсын төсвийн төсөлд тусгуулан хэрэгжүүлэх**<br><br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн болон ерөнхий эрлийн ажлын төлөвлөгөөнд алтны сэдэвчилсэн судалгааны ажлыг явуулахаар тусгах<br><br>- Хэтийн төлөв бүхий талбайд сэдэвчилсэн судалгааны ажил явуулж үнэлгээ өгөх<br><br>Хүрэх үр дүн 2.1: /2017-2018/<br><br>Алтны сэдэвчилсэн судалгааны ажил хийгдэж нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөгдсөн байна. | 2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл<br><br>Алтны хэтийн төлөв бүхий бүс, нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны алтны хэтийн төлөвийг үнэлэх, алтн үнэлгээний сэдэвчилсэн судалгааны ажлыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын эдийн засаг, ни хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулсан. Энэ ажлыг 2017-2019 онд Монгол орны төв, зүүн хэмжээнд гүйцэтгэхээр "Гео Тех Импекс" ХХК шалгаран төслийг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 2017 онд төслийн судалгааны аж тэрбум төгрөг зарцуулсан байна. УУХҮЯ-2017/7 тоот гэрээний дагуу Монгол орны төв болон зүүн бүсийн нутагт хийж гүйцэтгэсэн сэдэвчилсэн судалгааны завсрын ажлын тайланг гаргаж, 2018 онд гүйцэтгэх төслийн ажлын төсвийн тодотголыг хэлэлцүүлсэн Монгол орны Төв болон Зүүн бүсийн алтны сэдэвчилсэн судалгааны ажил нь Монгол орны газар нутгийн 1/3 орчим талбайд т алтны орд, илрэлүүдийн байршлын зүй тогтлыг тогтоох чиглэлээр 1930-аад оноос эхлэн гүйцэтгэсэн судалгааны ажлуудын нэгтгэн дүгнэх, хээрийн шалгалтын ажлаар судлах замаар тухайн талбайн алтны хүдэржилтийн тархалтын зүй тогтлыг шинжлэх орчин үеийн түвшинд ангилж, улмаар хэтийн төлөв бүхий талбай , орд газруудыг илрүүлэн үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой аж Маршрутын судалгааны ажлаар 79 хэтийн төлөв бүхий талбайн жагсаалтыг гарган сорьцлолтыг ажлыг хийж шинжилгээнд хам хэд хэдэн сонирхол татахуйц эрдэсжсэн цэг, илрэл, хувирлын бүсүүдийг тогтоосон байна. Тухайлбал эхний ээлжинд шинээр тогто Бага уулын алт, ээсийн хувирлын бүсийг дурдаж болно. Уг төслийн хээрийн ажлын гүйцэтгэлийн үйл ажиллагаанд шуурхай хя УУХҮЯ, АМГТГ-аас газар дээр очиж явуулав. Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлвийн үнэлгээ хийх гео судалгааны ажлын "ТЗМ-Алт-2017" төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлуулсан. Төслий онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр 2018.0 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 6-р сарын 21-ний өдрийн А/157 дугаар тушаалаар батлуулсан. Хээрийн судалгааны гүйцэтгэснээр төлөвлөгөөт онд нутаг дэвсгэрийн 30%-ийг хамруулсан. 2018 онд 921,209,736.0 төгрөгийн төсөв баталж, оны байдлаар 921,000,000.0 төгрөгийн санхүүжилт олгосон. Төслийн 2018 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч мате хүлээн авсан. Төслийн хээрийн судалгааны ажлыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говь-Сүмбэр аймгийг бүрэн, Сэлэнгэ, Төв, Ду аймгийн зүүн хэсэг, Дорноговь аймгийн хойд, зүүн талын сумдыг хамруулан гүйцэтгэсэн бөгөөд нийтдээ 320000 км2 талбайг хам эрэл-шалгалтын ажлыг 3336 цэгт хийж, мэдээллийн санг үүсгэсэн. Хэтийн төлөв бүхий зарим талбайд геофизик, геохими, ге геоморфологийн судалгааг хийж үр дүнг боловсруулж байна.<br><br>Биелэлт |
| | **2.2 Алтжилт бүхий улсын өмнөд хил орчмын бүс, зарим тусгай хамгаалалттай газар нутагт геологийн судалгаар явуулж үнэлгээ өгөх, цаашдын чиглэлийг тодорхойлох** | Монгол орны өмнөд хил орчмын бүс нутгийн алтны орд газар, илрэлийн байршлын зургийг боловсруулж санг үүсгэж алтны нө мэдээллийн судалгааг төрөлжүүлсэн.<br><br>Монгол орны алтны хүдэржилт бүхий талбайнуудыг судлан хэтийн төлөв бүхий хэсгүүдийг тогтоож дүгнэлт гаргах Ажлын хэсг байгуулах тухай УУХҮС-ын тушаалын төслийг 2018 оны 12-р сарын эцсээр боловсруулсан. |

| | | |
|---|---|---|
| | - Алтжилт бүхий улсын өмнөд хил орчмын бүс, зарим тусгай хамгаалалттай газар нутагт алтны тойм судалгааг хийх<br><br>- Тойм судалгааг үндэслэн зарим талбайнуудад эрэл үнэлгээний ажлыг хийх нөхцлийг бүрдүүлэх<br><br>Хүрэх үр дүн 2.2: /2017-2020/<br><br>Тойм судалгааг хийж үнэлгээ өгөгдсөн байна | Биелэлт 30%<br><br>Хугацаа болоогүй |
| | **2.3 Алтны эрэл хайгуулын болон геологийн зураглалын ажилд олон улсад нэвтэрсэн тэргүүний дэвшилтэт техник, технологийг Монгол Улсад нутагшуулах, хайгуулын ажлын арга зүй, түүнд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх**<br><br>-Алтны эрэл хайгуул, зураглалын ажилд олон улсын туршлагаар батлагдсан тэргүүний дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх судалгааг гаргана.<br><br>- хайгуулын ажлын арга зүй, түүнд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулах<br><br>Хүрэх үр дүн 2.3: /2017-2020/<br><br>Олон улсын туршлага, орчин үеийн техник технологийг нэвтрүүлсэн байна | Геологийн 1:50000-н масштабтай зураглал, ерөнхий эрлийн ажлын хийх заавар, түүнд тавигдах шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах ажлын тайлан хүлээн авах зааврыг УУХҮС-ын 2017 оны 12-р сарын 12-ны А/236 тоот тушаалаар шинэчлэн баталсан.<br>Ашигт малтмалын төрлөөр хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж боловсруулах ажлын ерөнхий даалгаврыг боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/195 дугаар тушаалаар батлуулсан.<br>Тус даалгаврын хүрээнд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр ШУТИС-ийн эрдэмтэдийн баг алтны үндсэн, шороон орд, төрлөөр хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмж боловсруулан хэлэлцүүлэгт бэлтгээд байна.<br><br>Биелэлт 70%<br><br>Хугацаа болоогүй |
| | **2.4 Алтны хэтийн төлөв бүхий талбайд сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох** | Хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицолыг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 37 тоот тогтоолыг батлуулсан. Хайгуулын тусгай тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг боловсруулан Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. 2009-2014 онд хийгдсэн 1:50000-ны масштабтай Улсын геологийн эрэл шалгалтын ажлаар тогтоогдсон илрэл эрдэсжсэн цэгүүдийн мэдээллийг үндэслэн 1.6 сая га талбайг ялган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Хөрөнгө татах, өргөдлөөр талбай авах сонголт, боломжийг нэмэгдүүлэх үүднээс 18,2 сая га талбайг ялган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2014 оны 239, 2015 оны 511 дүгээр тогтоолуудаар батлагдсан сонгон шалгаруулалтаар олгох |

| | | |
|---|---|---|
| | **ажлыг тэргүүн ээлжинд зохион байгуулах**<br><br>- Алтны хэтийн төлөв бүхий талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг үргэлжлүүлэн эхлүүлнэ<br><br>- Алтны тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд орон нутгаас тавьдаг шаардлагыг тодорхой болгох<br><br>- Хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгох сонгон шалгаруулалтын талбайг зарлахдаа алтны хэтийн төлөв сайтай илрэлийн талбайнуудыг тэргүүн ээлжинд олгодог болох<br><br>Хүрэх үр дүн 2.4: /2017-2020/<br><br>Журамд өөрчлөлт орсноор өргөдлөөр болон сонгоноор олгогдох эрэл хайгуулын тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлсэн байна | боломжтой 8.6 сая га талбай байсан. ЗГ-ын 2017 оны 37, 234 дүгээр тогтоолуудаар сонгон шалгаруулалтаар олгох боломжто талбайг батлуулсанаар нийт сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбай 10.2 сая га болсон. ЗГ-ын 2014 оны 239, 2015 о дугээр тогтоолуудаар батлагдсан өргөдлөөр олгох боломжтой 18.2 сая га талбай дээр ЗГ-ын 2017 оны 106 дугаар тогтоолоор ' га талбайг батлуулсан.<br><br>2017 онд сонгон шалгаруулалтыг нийт 9 удаа зарлаж 95 талбай хамруулснаар одоогоо 29 талбайд тусгай зөвшөөрөл олгосон Шинээр 23 алтны ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2017 онд олгосон.<br><br>2018 оны 8 дугаар сарын 8-нд Засгийн газрын 243-р тоот тогтоолоор сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл талбайн солбицол батлагдсан байна. 2018 оны 8 дугаар сарын 22-ноос эхлэн өнөөдрийн байдлаар 6 багцаар 60-н талбайд 511 га-д хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласнаас эхний 6 удаагийн / СШ-25, СШ-26, СШ-27, СШ-28, СШ-2 30 /-р 291474,24 га бүхий 39-н талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох аж ахуй нэгжийг шалгаруулж өнөөдрийн байдлаар 217 га талбайд нийтдээ / 19 хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, 8 тусгай зөвшөөрөл олгох/ төсөл боловсруулж улсын төсөвт бо 13,860,763,160 төгрөг төвлөрүүлээд байна.<br><br>Биелэлт |
| | **2.5 Алтны нөөцийн бүртгэл, эрэл хайгуулын ажлын мэдээллийг тогтмол шинэчлэн, нөөцийн хөдөлгөөнийг жил бүр хийж баталгаажуулах**<br><br>- Алтны нөөцийн хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах:<br>- Алтны шороон ордуудын бүртгэл<br>- Алтны үндсэн ордуудын бүртгэл<br>- Алт агуулсан бусад металлын ордуудын бүртгэл<br><br>- Алтны мэдээллийн санг бий болгож төрөлжүүлэх | Монгол Улсын алтны ордуудын бүртгэгдсэн нөөцийг үндсэн болон шороон орд мөн алт агуулсан бусад металлын ордын төрл ялгаж ангилсан. 2017 онд Улсын ашигт малтмалын нэгдсэн тоо бүртгэлд шинээр алтны үндсэн орд-4, алтны шороон орд-24, 5,9 тонн алтны нөөцийг хүлээн авсан бол 2018 онд алтны үндсэн орд-5, алтны шороон орд 42 нийт 23,2 тн алтны нөөцийг тус хүлээн авсан байна. Ингээд нийтдээ 9 алтны үндсэн орд, 66 алтны шороон ордын нийт 29,1 тн алтны нөөцийг эрдэнэсийн сан бүртгэн авчээ.<br><br>АМГТГ-аас хийсэн судалгаагаар 2018 оны 3-р сарын 01-ний байдлаар Монгол Улсын хэмжээнд алтны эрдсийн сангийн нөөц а үндсэн ордын хувьд 533,8 тн, алтны шороон ордынх 57,1 тн байгааг тооцоолон гаргасан.<br><br>Биелэл |

| | | |
|---|---|---|
| | Хүрэх үр дүн 2.5: /2017-2020/<br><br>Алтны нөөцийн хөдөлгөөнийг тогтмол хийж, бүртгэлжүүлэлтийг сайжруулсан байна. | Хугацаа болоогүй |
| | 3-р зорилтын хүрээнд:<br><br>**3.1 Алтны олборлох үйл ажиллагаанд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, байгаль орчинд ээлтэй тэргүүний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх**<br>- Алтны үндсэн болон шороон ордуудад хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй тэргүүний дэвшилтэт техник технологийн судалгааг хийж, зөвлөмж боловсруулна.<br><br>- Тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх<br><br>Хүрэх үр дүн 3.1: /2017-2020/<br><br>Техник, технологи нэвтрүүлсэн байна<br><br>**3.2 Хариуцлагатай ил тод уул уурхайг хөгжүүлэх, олон улсын туршлага, алтны эдийн засгийн үр өгөөж, орон нутгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмэр, алтны борлуулалтаас олох орлогын зарцуулалтын талаар олон нийтэд сурталчлан ойлгуулахад чиглэсэн мэдлэг, боловсрол олгох сургалт зохион байгуулах** | 3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан<br><br>Алтны олборлолт, боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан АМГТГ-аас Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.8-д заасныг хэрэгжүүлэх, технологийн түвшний үнэлгээ хийх, үнэлэлт, дүгнэлт гарсны дараа холбогдох зөвлөмжийг боловсруулж шийдвэрлүүлэх ажлыг эхлээд байна.<br><br>ЭМЯ-аас бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн, тусламж үйлчилгээг сайжруулах, бичил уурхайчдын мэргэжлээс шалтгаалах өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг сайжруулах чадавх бэхжүүлэх багц ажлын хүрээнд бичил уурхайчид олноор төвлөрсөн Баянхонгор аймагт "Бичил уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд химийн бодисын хор, хөнөөлийн талаар хэрхэн сурталчлах талаар 2017 оны 6 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтад бичил уурхай бүхий Баацагаан, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянбулаг, Баянцагаан, Бөмбөгөр, Галуут, Жаргалант, Жинст, Шинэжинст, Хүрээмарал, Эрдэнэцогт, Баянлиг, Гурванбулаг, Заг сумдын эрүүл мэндийн төвийн эмч нар болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нар, Эрүүл мэндийн газрын дарга, мэргэжилтэн нийт 21 хүн оролцсон. Сургалтад оролцсон эмч нар бичил уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд химийн бодисын хор, хөнөөлийг сурталчлах сургалтыг Баянхонгор аймгийн Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг сумдад хийсэн. Сургалтад нийт бичил уурхайчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд болох 1,000 хүн хамрагдсан байна<br><br>Биелэлт 70%<br><br>Хугацаа болоогүй<br><br>УУХҮЯ. Тогтвортой хөгжлийн төлөөх олон улсын хүрээлэн хамтран "Уул уурхай, ашигт малтмал, металл, тогтвортой хөгжлийн засгийн газар хоорондын форум" байгууллагын дэмжлэгтэйгээр "Монгол Улсад Уул уурхайн салбарын бодлогыг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах нь" сургалтыг 3 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Энэхүү сургалтын хүрээнд алтны шороон ордын олборлолтын үйл ажиллагаа зонхилж буй Сэлэнгэ, Дархан, Төв аймгийн холбогдох сумдын Засаг дарга, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнг урьж оролцуулан уурхайн хаалтын бодлогын ач холбогдол, хаалтын бодлогыг сайжруулах хэрэгцээ шаардлага, төслийн үе шат бүрд хаалтын эрсдэлийг удирдах чиглэлээр болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлэх нь зэрэг сэдвүүдээр олон улсын экспертүүд болон дотоодын зөвлөхүүд илтгэл танилцуулж нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлсэн. Хэлэлцүүлгийн дараа УУБГ-ын дарга Ж.Ганбаатар сургалтын талаар хэвлэл мэдээлэлд ярилцлага өгсөн. |

| | | |
|---|---|---|
| | - Төр, иргэд, олон нийтийн оролцоотойгоор хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх олон улсын туршлагыг судлах ажлыг өргөжүүлэх:<br>-Геологийн судалгааны шатанд<br>-Хайгуулын шатанд<br>- Олборлолтын үе шатанд холбогдох сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна<br><br>Хүрэх үр дүн 3.2: /2017-2018/<br><br>Сургалтыг зохион байгуулсан байна. | Мөн 3 дугаар сарын 24-ний өдөр Сэлэнгэ аймагт томилолтоор ажиллахдаа Засаг дарга болон сумдын засаг дарга холбогдох хүмүүстэй уулзаж ярилцсан.<br><br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны байранд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төри байгууллагын 20 гаруй ажилтанд 2017 оны 1-р сарын 27-нд "Эрдэс, баялаг олборлох үйл ажиллагааны үе шат иргэдийн оролцоо", металлын үйлдвэрлэлийн үе шат, Ашигт малтмалын хайгуул" сэдвээр ГБГ-аас сургалт явуулсан.- Уул уурхай, хүнд үйлдвэри (УУХҮЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын алба (ОҮИТБС), Нээлттэй нийгэм форум (Н хооронд 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран аж харилцан ойлголцлын Санамж бичигт гарын үсэг зурсан. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого болон ОҮИ хэрэгжүүлэх хүрээнд гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр Талууд 2014 оноос хамтран ажилласны үр дүнд Эрдэс баялгийн гэ мэдээллийн цахим санг (www.iltodgeree.mn/www.resourcecontracts.mn) байгуулснаа олон нийтэд танилцуулж, албан ёсны нээлтээ<br><br>Биелэлт |
| | **3.3 Ойролцоо болон хил залгаа орших тусгай зөвшөөрөл бүхий алтны ордуудын ашиглалтын үеийн тосгон, дэд бүтэц, зам, цахилгаан хангамж болон алт боловсруулах үйлдвэрийг цогц байдлаар төлөвлөн байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх**<br><br>- Алтны ордууд болон бусад төрлийн ашигт малтмалын ордуудын дэд бүтэц, бүчилсэн хөгжилтэй уялдуулсан судалгааг боловсруулна.<br><br>- Алт боловсруулах үйлдвэрийг цогц байдлаар барьж байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх<br><br>Хүрэх үр дүн 3.3: /2017-2020/<br><br>Холбогдох судалгааг хийсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Монгол Улсын нутаг дэвсгэрт илэрсэн алтны үндсэн ордуудын байршлын зураглал (бүсчилсэн байдлаар), эзэмшигчдийн б мэдээлэл болон нөөцийн бүртгэлийн талаарх судалгааг гаргасан. Нөөц тогтоогдсон зарим алтны ордуудын төслийн ТЭЗҮ з батлагдан гараагүй байгаа тул цогц байдлаар төлөвлөлт хийгдээгүй байна.<br><br>Биелэл<br><br>Хугацаа бо |

| | | |
|---|---|---|
| | **3.4 Стратегийн ач холбогдол бүхий алтны ордуудын ашиглалтыг эхлүүлэх**<br><br>- Стратегийн ач холбогдол бүхий алтны ордуудыг ашиглах бэлтгэл ажлыг хангах<br><br>- Орд ашиглах гэрээг байгуулах<br><br>- Олборлолтын ажлыг эхлүүлэх<br><br>Хүрэх үр дүн 3.4: /2017-2018/<br><br>Ордуудыг ашиглах бэлтгэл ажлыг хангаж олборлолтыг эхлүүлсэн байна. | Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах хүрээнд Орд ашиглах гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээр хийх Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд Ажлын хэсгийг Уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатараар ахлуулан байгуулсан. Уг Ажлын хэсэг Орд ашиглах гэрээний төсөл болон Хөрөнгө оруулалтын гэрээний төслүүдийг боловсруулан танилцуулсан.<br><br>Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлж, орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг хэлэлцэн тусгах, гэрээний төслийг бэлтгэхэд оролцон санал боловсруулсан. Дэд ажлын хэсэг нийт 4 удаа хуралдсан. Орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний анхны төслүүдийг боловсруулан "Сентерра Гоулд" ХХК руу санал авахаар хүргүүлсэн.<br><br>УУХҮ-ийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/21 тоот тушаалаар батлагдсан Стратегийн ордын талбайн хил зааг тогтоох ажлын хэсэгт ажиллаж дараах нэр бүхий ордын талбайн хил заагийг тогтоох ажлыг бэлтгэл ажлыг хангаж ажилласны дүнд Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.12 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд Гацууртын ордын стратегийн ордын талбайн хил заагийг 2017 оны 4 дүгээр сарын 4-ны өдөр 3025 га талбайгаар тогтоосон.<br><br>Ордыг ашиглах явц иргэдийн хөдөлгөөний эсэргүүцэлтэй тулгарч шүүхийн шатанд шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна.<br><br>Биелэлт 50% |
| | **3.5 Алтны болон алт агуулсан бусад ашигт малтмалын ордуудад судалгаа хийж, үнэлгээ өгөх замаар эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай нөхцөлийг тодорхойлсны үндсэн дээр зохих дэмжлэг үзүүлэх**<br><br>- Алтны болон алт агуулсан бусад ашигт малтмалын ордуудын судалгааг хийх<br>- Ойрын үед хэрэгжих боломжтой төслүүдийн судалгаа гаргах<br>- Ашиглалтад оролгүй хүлээгдэж байгаа ордуудын нөхцөл байдлын судалгаа гаргах<br><br>- Ордыг ашиглах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна<br><br>Хүрэх үр дүн 3.5: /2017-2020/ | 2017 оны 5-р сарын 19-нд УУХҮЯ-нд 30 гаруй алтны үндсэн орд эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзах уулзалтыг зохион байгуулж, үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, тулгарч буй хүндрэл, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж санал солилцов.<br><br>Ойрын хугацаанд хугацаанд хэрэгжих боломжтой алтны ордуудын 69 төслийн жагсаалт, уулын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлсэн байдлын талаарх 127 тусгай зөвшөөрлийн мэдээллийг гаргаж Хөгжлийн банкинд хүргүүлсэн.<br><br>Алт олборлолтыг 2017 онд 20 тн-д хүргэж алт олборлолтын төлөвлөгөөг 111%-р давуулан биелүүлсэн бол 2018 онд 20 тонн алт олборлохоор төлөвлөснөөс оны эцсээр Монголбанкинд 21.9 тонн алт тушаагдаж төлөвлөсөн үндсэн төлөвлөгөө зорилтоо амжилттай биелүүлээд байна<br><br>Монгол Улсын нутаг дэвсгэрт илэрсэн алтны үндсэн ордуудын байршлын зураглал (бүсчилсэн байдлаар), эзэмшигчдийн бүртгэл, мэдээлэл болон нөөцийн бүртгэлийн талаарх судалгааг АМГТГ-аас 2018.03.09-ний өдөр хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. |

| | | |
|---|---|---|
| | Төлөвлөлтийн дагуу алт олборлолтыг эхний жил 18 тн, 2018 онд 20 тн-д хүргэнэ. 2020 онд 25 тн-д хүргэнэ.<br><br>Судалгааг гаргаж, аж ахуйн эргэлтэнд оруулах үнэлгээ хийгдсэн байна.<br><br>**3.6 "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хууль"-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд шороон болон үндсэн ордуудын нөөцийг цаашид зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх**<br><br>-3.6.1 Хуулийн хэрэгжилтэнд хамрагдсан талбайн бодит судалгааг гаргаж холбогдох дүгнэлтийг гаргана.<br><br>- Хуулийн хэрэгжилтийг хангах зохистой шийдлийг гаргаж хэрэгжүүлнэ.<br><br>Хүрэх үр дүн 3.6.1: /2017-2018/<br><br>Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд шороон болон үндсэн ордуудын нөөцийг зохистой ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байна.<br><br>3.6.2 Ойн сан бүхий газрын хилийн заагийг тухайн аймагт хийгдсэн хамгийн сүүлийн ойн зохион байгуулалтын зураглалаар тогтоож байх чиглэлээр асуудал боловсруулан ЗГ-т оруулах | Биелэлт<br><br>БОАЖЯ-наас "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтма олборлох, ашиглахыг хориглох тухай хууль"-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор усан сан газрын хамгаалалтын бүсэд ашиглалт хийх 20 аж ахуйн нэгжтэй гэрээг эцэслэн байгуулж АМГТГ-т хүргүүлсэн.<br><br>Урт нэртэй хуулийн үйлчлэл байсан 366 ашиглалтын тусгай зөвшөөрлөөс 133 тусгай зөвшөөрөл хуулийн үйлчлэлээс гарсан үүнээс 17 тусгай зөвшөөрлийн талбайд АМГТГ, МХЕГ, Аймгийн засаг дарга, БОАЖЯ, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар оролцсон гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулах боломжтой болжээ.<br><br>БОАЖЯ-наас "Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээг авах, нөхөн сэргээл журамд"-д өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн боловч шаардлагагүй гэж үзсэн байна.<br><br>Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, аши хориглох тухай хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаар тайланг сар бүрийн 15-ны дотор гаргаж<br>Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, аши хориглох тухай хуулийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж Ашигт малтмал, газрын тосны даргад 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр танилцуулагдан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2018 оны 11 дүгээр са нд хүргүүлсэн.<br><br>Биелэл<br><br>Ойн сан бүхий газартай давхацсан талбайд ашиглалт хийх аж ахуйн нэгж, ашиглах нөөц, ойг хамгаалах, ойжуулах талаар иру саналыг судлан "Дөрвөн тал" болон "Рич мөнх" ХХК-нд "Ойн тухай" хуулийн 30.2-д заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллах дүгн гарган хүргүүлсэн байна. |

| | | |
|---|---|---|
| | Хүрэх үр дүн 3.6.2: /2017-2018/<br><br>Алтны зарим ордыг ашиглах, ойн сан бүхий газрыг бодитой тогтоох, хамгаалалтад авах арга хэмжээ хэрэгжсэн байна. | Биелэлт 30% |
| | 3.6.3 Гадаргын усны мэдээллийн санд өөрчлөлт оруулах Нөхөн сэргээсэн газрыг урсац бүрэлдэх эх, энгийн хамгаалалтын бүсэд буцаах чиглэлээр Засгийн газрын 2015 оны 120 тоот тогтоолоор баталсан "Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-д өөрчлөлт оруулах<br><br>Хүрэх үр дүн 3.6.3: /2017-2018/<br><br>Алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн бичиг баримтын бүрдэл хангагдаж нөхөн сэргээлтийг хийх эдийн засгийн хөшүүрэг бий болсон байна.<br><br>3.6.4 Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг тэмдэгжүүлэх, хамгаалах, үүссэн зөрчлийг арилгах арга хэмжээг тодорхойлж, аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах<br><br>Хүрэх үр дүн 3.6 4 : /2017-2018/ | Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ дүгнэх ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүдээс 2017 оны гэрээний биелэлтийн тайлан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гэрээний биелэлтийн талаар санал, дүгнэлт хүлээн авч, гэрээг дүгнэх талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай санал солилцсон. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэлүүд, төрийн байгууллагуудын ойлголтын зөрүүг арилгах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай уулзалт зохион байгуулж 2 сайдын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулж ажиллахаар тохиролцсоны дагуу ажлын хэсэг байгуулах тушаалын төсөл болон ажлын удирдамж боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус тус хүргүүлсэн.<br>2018 онд Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт хийж, нөхөн сэргээх үйл ажиллагааны 12 гэрээ нэмж байгуулсан.<br><br>Хориглосон талбайн хилийн заагтай давхцалтай хэсгийг хасуулж солбицолд өөрчлөлт оруулах 59 аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлж, сонсох ажиллагаа явуулах зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Түүнчлэн цуцлах 64 ашиглалтын тусгай зөвшөөрлийн жагсаалт гаргаж Кадастрын хэлтэст хүргүүлсэн.<br><br>Хуулийн үйлчлэлд хамрагдсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 67 аж ахуйн нэгж /давхардсан тоогоор/-д мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br><br>Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 6 аж ахуйн нэгжтэй усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулах гэрээ байгуулж, онцгой хамгаалалтын бүсийг хасуулж солбицолд өөрчлөлт оруулсан.<br><br>Хуулийн үйлчлэлд хамрагдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санг үргэлжлүүлэн хөтөлж хамрагдах мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн бүртгэж байна.<br><br>Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/95 тоот тушаалаар байгуулагдаж, 2 удаа хуралдаж байгууллагын дотор шийдвэрлэж болох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж болох асуудлын талаар хэлэлцэж, шийдвэрийг Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн<br><br>Сэлэнгэ голын сав газрын захиргаа 50, Хараа-Ерөө голын сав газрын захиргаа 27, Хануй голын сав газрын захиргаа 22, Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргаа 13, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа 20, Туул голын сав газрын захиргаа 50 талбайн хэмжээнд усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлсэн байна.<br><br>Биелэлт 90% |

| | | |
|---|---|---|
| | Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг тэмдэгжүүлэх, хамгаалах, үүссэн зөрчлийг арилгах арга хэмжээ хэрэгжсэн байна.<br><br>**3.7 Үнэт металлын сорьцын хяналтын байгууллагыг бэхжүүлж техник технологийг шинэчлэх, алт олборлолтын томоохон бүс нутагт сорьцын салбар лаборатори байгуулах нөхцөлийг хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах**<br><br>- Стандарт, хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газрын лабораторийн техник технологийг шинэчлэх:<br>- Сорьцын лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх Алт тушаалтын бүртгэлийг сайжруулах<br><br>- Алт олборлолтын томоохон бүс нутгуудад сорьцын лаборатори байгуулах нөхцөлийг бүрдүүлэх<br><br>Хүрэх үр дүн 3.7: /2017-2018/<br><br>Сорьцын хяналтын албын чадавхийг бэхжүүлж, техник технологийг шинэчилсэн байна. | 2017 онд Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслөөс ҮМСХГ-ийн техникийн хүчин чадлыг нэмэ зорилгоор Итали Улсад үйлдвэрлэсэн 3 кг хүртэлх жинтэй алт хайлуулах 40 сая төгрөгийн өртөг бүхий индукцийн зуухыг хэр төхөөрөмжийн хамт худалдан авч суурилуулж өгсөн.<br><br>Үнэт металын сорьцын лабораторийг байгуулах боломжийн талаар санал ирүүлэхийг хүссэн Монгол банкны 2018 оны 2 дугаа 19-ний өдрийн А-1/204 тоотын дагуу Баруун болон хойд бүсийн бичил уурхайн дүгнэлт гарсан талбай, олборлолтын мэдээг ху лаборатори байгуулахыг дэмжсэн.<br><br>УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар Алт нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгох, орон нут сорьцлох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах талаар судалгаа хийж, санал боловсруулах үүрэг бүхий Ажлы байгуулж ажилласан. Ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн "Лаборатори байгуулах тухай" Засгийн газрын 2018 оны 9 дүгээ 5-ны өдрийн 275 дугаар тогтоол, "Орон нутагт алт худалдан авах үйл ажиллагааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А-108 дугаар тушаал батлагдан гарч, Дархан-Уул айма оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Баянхонгор аймагт 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр алтны сорьц тогтоох, худалдан авах Д Уул, Баянхонгор аймаг дахь Стандарт, хэмжил зүйн салбар лаборатори Швейцарын хөгжлийн агентлагаас 500 сая Монголбанкнаас 265 сая төгрөг, орон нутгийн ЗДТГ-аас 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орж алт олборло томоохон бүс нутагт сорьцын лаборатори байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлэн 2018 оны төгсгөлөөр нийтдээ 222 кг алт ху авсан байна.<br><br>Биелэлт |
| | **3.8 Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулах**<br><br>- Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах судалгааг гаргана | Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2017 оны 3-р сарын 29-ний өдрийн А/62, А-98 тоот хам тушаалаар Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэ УУХҮЯ, Монголбанк, Стандарт хэмжил зүйн газар, "Эрдэнэс Монгол"ХХК -ийн төлөөлөл оролцсон Ажлын хэсгийг байгуулсан. хэсгийн календарчилсан төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн технологийн харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Монго ARGOR-HERAEUS S.A. компанийн төлөөлөлтэй алт цэвэршүүлэх үйлдвэрийн суурь судалгааг хийлгэх асуудлаар Ажлын хэсгийн у зохион байгуулсан. Ажлын хэсэг Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах тухай, алтны зах зээлийн төлөв, дунд хугацаа |

| | | |
|---|---|---|
| | -Алт цэвэршүүлэх үйлдвэрийг барих ТЭЗҮ-ийн тооцооллыг боловсруулах<br><br>- Алт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна.<br><br>Хүрэх үр дүн 3.8: /2017-2020/<br><br>Үйлдвэрийг байгуулсан байна. | хандлага зэрэг судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Алт цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах боломж, нөхцөлийн талаар санал боловсруулж, суурь судалгааг хийх үүрэг бүхий Ажлын хэсэг УУХҮ-ийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан А/62-А/98 тушаалаар байгуулагдан ажилласан. Ажлын хэсэг Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах боломжийн талаарх судалгааг хийж, санал дүгнэлтийг боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Монголбанкны ерөнхийлөгчид танилцуулсан.<br><br>Алт цэвэршүүлэх, алт олборлох үйл ажиллагаа эрхлэх Төрийн өмчит компанийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн харъяанд байгуулах асуудлыг тус компанийн 2018.03.13-ны өдрийн ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар хийгдсэн судалгаа, төслийн талаарх танилцуулгыг Сайдын зөвлөлийн хуралд 2018.03.13-ны өдөр танилцуулсан.<br><br>Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулахтай холбогдуулан Бүгд найрамдах Казахстан Улсын "Таукен Алт" компанийн төлөөлөлтэй 2018.03.22-ны өдөр уулзалт зохион байгуулж, "Таукен Алтын" компанитай "Эрдэнэс Монгол" ХХК хамран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.<br><br>Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 4-ны А-303 дугаар тушаалаар Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын цогц төлөвлөгөө боловсруулж, судалгаа хийх, холбогдох ажлыг эхлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.<br><br>Алт цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ гүйцэтгэх тендер шалгаруулалтыг зарлах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br><br>Биелэлт 70%<br><br>Хугацаа болоогүй |
| | **3.9 Алтыг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх**<br><br>- Алтыг боловсруулах гар урлалын эцсийн бүтээгдэхүүн гаргах нарийвчилсан судалгааг гаргана.<br><br>- Алтны сорьцын хяналтын үйл ажиллагааг сайжруулна<br><br>- Үнэт металлаар хийх уран дарханы гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих<br><br>Хүрэх үр дүн 3.9: /2017-2020/ | 2017 онд Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Швейцарийн Хөгжлийн агентлаг (SDC) хамтран хувиараа алт олборлогч иргэдийн олборлосон алтаар эцсийн бүтээгдэхүүн хийх, улмаар эдгээр иргэдийг уран дархны чиглэлээр суралцаж, хөрвөн ажиллах боломжийг бий болгох зорилгоор уран дархчуудын дунд уралдаан зарлаж. "Уламжлалаар ирээдүйг гоёхуй" нэртэй үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэнд 27 уран дархны 64 бүтээлийг оролцуулсан. Эдгээр бүтээлүүдийг ээмэг, бөгж, зүүлт гэсэн гурван төрөлд ангилан хувааж, тус бүрд нь шилдгүүдийг тодруулсан байна.<br><br>Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад үнэт эдлэл, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын политехник коллежид Үнэт эдлэлийн дархны сургалтын шинэ танхим нээгдсэн. Уг танхим ашиглалтад орсноор Монгол орны байгалийн үнэт баялаг нь эцсийн бүтээгдэхүүн болж дотоодын болон гадаад зах зээлд гарах, Монголын түүхэн уламжлал дээр суурилсан Монгол дархны мэргэжлээс орчин үеийн урлагийн төрлийг хослуулсан сургалт явуулах боломж бүрдсэн. Үнэт эдлэлийн дархны ангийн сургалтын хөтөлбөрийг ХБНГУ-ын мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөртэй уялдуулан шинэчилж боловсруулсан. Уг хөтөлбөрийн дагуу 2018 оны 1 сарын 29-өөс 1.5 жилийн болон богино хугацааны сургалт, дадлагын хичээлийг орчин үеийн шинэ тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл дээр явуулах боломжийг оюутан суралцагчдад олгосон юм. |

| | | |
|---|---|---|
| | Бүтээгдэхүүний төрөл, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн байна. | Биел: |
| | **3.10 Дэлхийн түвшний алтны олборлолт, худалдаа, олон улсын зах зээлийн үнэ, Монголбанкны сар бүрийн алтны худалдан авалтын тухай мэдээллийн нэгдсэн сан бий болгох**<br><br>Дэлхийн түвшний алтны олборлолт, худалдаа, олон улсын зах зээлийн үнэ, Монголбанкны сар бүрийн алтны худалдан авалтын тухай мэдээллийн нэгдсэн сан бий болгох<br><br>Хүрэх үр дүн 3.10: /2017-2018/<br><br>мэдээллийн нэгдсэн санг бий болгосон байна | Монголбанкны цахим хуудсан дээр Монголбанкны алт худалдан авалтын сар бүрийн мэдээг нэгтгэсэн файл боловсруулан байрш болно. Мөн Монголбанкны алт худалдан авах үнийг баазыг Монголбанкны цахим хуудсанд байршуулсан.<br><br>Монголбанкны алт худалдан авалтын сар бүрийн мэдээг боловсруулан Монголбанкны цахим хуудаст сар бүр байршуулж байна.<br><br>Биелэлт |
| | **3.11 Алтны олборлолт, боловсруулалт, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын үйл ажиллагааг стандартын түвшинд гүйцэтгэж, Монголбанкинд алт тушаасан үндэсний компанийн үйл ажиллагаанд зохих дэмжлэг үзүүлэх**<br><br>- Монголбанкинд тушаасан алт, алтны олборлолтын судалгаа,<br>- Нөхөн сэргээлт, уурхайн хаалтын үйл ажиллагааны судалгааг хийх<br><br>- Тэдгээрийг урамшуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, холбогдох санал зөвлөмжийг гаргах<br><br>Хүрэх үр дүн 3.11: /2017-2020/ | УУХҮЯ-наас зохион байгуулсан Уул уурхайн 95 жилийн ойн арга хэмжээний үеэр уул уурхайн салбарын 2017 оны “Тэргүүний сэргээгч” ААН-р алт олборлогч “Монголын үндэсний олборлогч” ХХК-ийг шалгаруулж УУХҮСайдын батламж гардуулсан.<br><br>2018 оны 03-р сарын 15-16-ны хооронд зохион байгуулагдсан “Mongolia Gold-2018” чуулганы үеэр Монгол банкнаас алт тогт тушаасан 13 компанийн төлөөлөлд шагнал гардуулсан. БОАЖЯ-наас тэргүүний нөхөн сэргээлт хиисэн “Шар нарст” ХХК-ийг байгаль салбар үүсэн хөгжсөний 30 жилийн ойгоор өргөмжлөл олгож, шагнаж урамшуулсан байна. |

| | | |
|---|---|---|
| | Үйл ажиллагааг дэмжиж урамшуулсан байна.<br><br>**3.12 Алтны үйлдвэрлэлд ажиллагсдын чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа алт олборлогч аж ахуйн нэгж, ажиллах хүчний судалгааг хийж урамшууллын механизмыг бий болгох**<br><br>- Алт үйлдвэрлэлд ажиллагсадын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулж байх<br><br>- Он удаан жил үр бүтээлтэй ажиллаж байгаа:<br>- алт олборлогч аж ахуйн нэгж ,<br>- албан хаагчдын судалгааг хийх,<br>- Тэдгээрийн хөдөлмөрийг үнэлэх, амжилт гаргасан байгууллага, хүмүүсийг урамшуулах ажлыг жил бүр зохион байгуулах<br><br>Хүрэх үр дүн 3.12· /2017-2020/<br><br>Сургалтыг зохион байгуулсан байна. Холбогдох судалгааг гаргаж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. | Биелэлт 100%<br><br>2017 онд АМГТГ-ын УУҮТХ-т ирүүлсэн алтны салбарт ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны тайлангаар нийт 94 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс алтны шороон ордод нийт 80 аж ахуй нэгжийн нийт 5115 ажиллагсад ажиллаж байгаагаас 12% нь эмэгтэй ажилчид эзэлж байна.Алтны үндсэн ордод нийт 5 аж ахуй нэгжийн нийт 1062 ажиллагсад ажиллаж байгаагаас 8% нь эмэгтэй ажилчид эзэлж байна. Алтны үүсмэл ордод нийт 2 аж ахуйн нэгжийн 59 ажиллагсад ажиллаж байгаагаас 15% нь эмэгтэй ажилчин ажиллаж байна.<br>Уул уурхайн 95 жилийн ойн арга хэмжээний үеэр Уул уурхайн сайд /хуучнаар/-ын 2012 оны 67 тоот тушаалын дагуу Геологи, уул уурхайн салбарын 2017 оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулсан бөгөөд “Тэргүүний нөхөн сэргээгч” аж ахуйн нэгж, байгууллагаар алт олборлогч “Монголын үндэсний олборлогч” ХХК, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг эрхэмлэгч” байгууллагаар “Монполимет” группыг тус тус шалгаруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын батламж гардуулсан.<br><br>2017 онд алт үйлдвэрлэлийн салбараас 10 орчим ажилтан салбарын тэргүүний ажилтнаар шагнагдсан бол 2018 онд алтны салбарт ажиллаж буй ААН-с 20 гаруй ажилтан салбарын тэргүүний ажилтнаар шагнагдсан байна.<br><br>Биелэлт 90% |
| | 4-р зорилтын хүрээнд.<br><br>**4.1 алтны үйлдвэрлэлийн улмаас эвдрэлд орсон талбайн бүртгэл тооллого болон нарийвчилсан байр зүйн зураглал хийж, хохирлын хэмжээг тогтоосны үндсэн дээр нөхөн сэргээлт** | 4-р зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан<br><br>18 аймгийн хэмжээнд нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай, хууль бусаар олборлолтод өртсөн газар, эвдэрсэн газрын тооллогыг шинэчлэн хийхээр мэдээллийг БОАЖЯ болон АМГТГ-ын мэдээллийн санд хүргүүлэн дээрх судалгаанд шүүлт хийгдэн хууль бус олборлолтод өртсөн, нөхөн сэргээх шаардлагатай талбайг ялгасан<br><br>Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/71 тоот тушаалаар 2017-2018 онд “Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого хийх ажлын удирдамж” батлагдсан. Тооллогын дүнгийн талаар Засгийн газрын хуралд |

| | | |
|---|---|---|
| | **хийх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан буруутай хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх замаар алт олборлогч аж ахуйн нэгжийн хариуцлагыг өндөржүүлэх, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**<br>- Алтны орд газрын эвдрэлд орсон талбайн судалгаа гаргана<br>- Нөхөн сэргээлт хийх талбайн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулна<br>- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх<br>Хүрэх үр дүн 4.1: /2017-2018/<br>Төлөвлөгөөг боловсруулж, нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.<br>Судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээллийн сантай болсон байна. | 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдөр танилцуулж 36 тоот тэмдэглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тооллогыг 2018 онд дуусгах талаар үүрэг өгсөн.<br>Орон нутгийн хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийлгэхтэй холбоотой үйл ажиллагаанд үнэлэлт өгөх үүрэг бүхий Ажлын х УУХҮС-ын 2018 оны 5-р сарын 1-ний өдрийн А/90 дугаар тушаалаар байгуулан ажилласан.<br>АМГТГ-аас 2017 оны батлагдсан ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны тайлангийн байдлаар 13 аймгийн 34 сумдууд ал ордны эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбайн судалгааны тайланг УУХҮЯ-нд хүргүүлсэн. Үүнд:<br>Тус онд эвдрэлд орсон талбай – 682.57 га<br>Тус онд хийгдсэн нөхөн сэргээсэн талбай – 508.1 га<br>Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ын тоо – 94 байна.<br>Нөхөн сэргээлтэнд зарцуулсан зардал 2,110.6 сая төгрөг, байгаль орчинг хамгаалахад зарцуулсан зардал 1,095.7 сая төгрө байна<br>БОАЖЯ-наас 2017-2018 онд 3 удаа сургалт семинар зохион байгууллаа. Тооллогыг аймаг, нийслэлийн Засаг дарга, нийсл Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар удирдан зохион байгуулж, тус яамны Хүрээлэн буй байгалийн нөөцийн удирдлагын газар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тооллого хийх ажилд орон нутгийн төсвөө гаруй сая төгрөг зарцуулсан байна.<br>Өнөөдрийн байдлаар уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын хэмжээ урьдчилсан байдлаар гарсан болно. Үүнд:<br>- Эвдэрсэн газрын хэмжээ 27405,46 га<br>- Нөхөн сэргээх шаардлагатай орхигдсон газрын байршлын тоо 1100, талбайн хэмжээ 8871,18 га<br>Мэдээллийг www.eic.mn мэдээллийн сангийн "Газрын хэвлий, ашигт малтмалын мэдээллийн сан" гэсэн хэсэгт аймаг, сум б эвдэрсэн газрын байршил, эвдрэлийн шалтгаан, эвдрэлийн хэмжээг харж ашиглах бүх мэдээллийг PDF, excel байдлаар х хэвлэх боломжийг оруулсан.<br>Биелэлт |
| | **4.2 Алт олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлж, тэдгээрт тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгох, төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх**<br>- Алт олборлогчид, борлуулагчдын нэгдсэн судалгаа гаргах | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн судалгаа, уурхайчид, нөхөрлөлийн судалгааг авч АМГТГ-т мэдээллийн санг үүсгэсэн.<br>2018 онд нийт 549 аж ахуйн нэгж 728 тусгай зөвшөөрөл эзэмшигч төлөвлөгөө ирүүлсэн байна. Үүнд "Байгаль орчныг хам уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээ" ирүүлсэн 176 ирүүлээгүй буюу албан бичиг хүргүүлсэн 111, Х төлөвлөгөө ирүүлсэн 355, Төлөвлөгөө баталгаажуулаагүй 41, татгалзсан 45 зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байна.<br>2018 оны 11-р сарын 22-ны өдөр УУХҮЯ, Монголбанк, АМГТГ, ТЕГ,Швейцарын хөгжлийн агентлаг, орон нутгийн удир оролцуулсан "Бичил уурхайн алт нийлүүлэлтийн сүлжээ, алтны худалдааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь" гэсэн |

| | | |
|---|---|---|
| | - Алт олборлогчдыг бүртгэлжүүлэх<br><br>-Бүртгэлжүүлсний үндсэн дээр хяналтын тогтолцоог бий болгоно. Холбогдох журмыг боловсруулна<br><br>Хүрэх үр дүн 4.2: /2017-2018/<br><br>төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах нөхцлийг бүрдүүлсэн байна, холбогдох журмыг боловсруулсан байна. | семинарыг зохион байгуулж, алтны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам, алтны гарал үүсэл, худалдааг ил тод болгох, бичил уурхайн алтыг албан сүлжээгээр худалдаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар хэлэлцэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан.<br><br>Биелэлт 70% |
| | **4.3 Алтны орд ашигласны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн үнэлгээг тодорхойлох олон улсын туршлагыг судлан холбогдох аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх**<br><br>4.3.1 - Олон улсын туршлагыг судалж зөвлөмж гаргана<br><br>- Зөвлөмжийн дагуу үнэлгээ тогтоох аргачлалыг боловсруулж нэвтрүүлнэ<br><br>Хүрэх үр дүн 4.3.1: /2017-2018/<br><br>Холбогдох аргачлалыг боловсруулж нэвтрүүлсэн байна | Алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд бусад орны сайн туршлагаас суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын гишүүд, УУХҮЯ, АМГТГ, Монголбанк, ҮМСХГ-ын төлөөллийг оролцуулан Латин Америкийн Колумб, Эквадор улсад туршлага судлах арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд бусад орны сайн туршлагаас суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын гишүүд, УУХҮЯ, АМГТГ, Монголбанк, ҮМСХГ-ын төлөөллийг оролцуулан Латин Америкийн Колумб, Эквадор улсад туршлага судлах арга хэмжээг УУХҮЯ-ны хүсэлтээр зохион байгууллаа.<br><br>Биелэлт 30% |
| | 4.3.2 Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх<br><br>Хүрэх үр дүн 4.3.2: /2017-2018/ | БОАЖЯ-ны ТНБД-ын 2018 оны 11-р сарын 20-ны өдрийн а/577 тоот тушаалаар Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт ашигт малтмал ашиглаж буй “Монгол газар” ХХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс 2018 оны 12-р сарын 1-2-нд Архангай аймгийн Цэнхэр суманд очиж ажиллан “Монгол газар” ХХК-ийн алт олборлолт хийсэн нийт талбайд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажлыг орхигдуулсан, байгаль орчинд учруулсан хохирол, тэдгээрт нөхөн сэргээлт хийх ажлын зардлын хэмжээг тооцон гаргаж тусгай зөвшөөрлийг цуцлах боломжтой гэсэн дүгнэлтийг гаргасан байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | Нөхөн сэргээлтийн ажлыг орхигдуулахгүй байх нөхцөл хэрэгжсэн байна. | | Биел: |
| | 4.3.3 Уул уурхайн хуулинд БОХ, НС үүргээ биелүүлээгүй болох нь уулын үйлдвэрийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд түтгэлзүүлэх, хүчингүй болгох чиглэлээр тусгах<br><br>Хүрэх үр дүн 4.3.3: /2017-2018/<br><br>БОХ, НС үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ илүү хатуу, хэрэгжих нөхцөл бүрдсэн болсон байна. | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7-р сарын 4-ний өдрийн хуралдаанд Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй ААН-ийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг боловсруулан танилцуулсан.<br><br>Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын нутагт ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Юу Энд Би" ХХК ашиглалтын MV-0028 талбайд уурхайн олборлолтын ажил эхлүүлэх бичиг баримт бүрдүүлээгүй хууль бусаар үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг нө сэргээх үүргээ биелүүлээгүй тул АМТХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтын дагуу 2017.06.28-ны 17/01 дүгнэлт гарч АМГТГ хүргүүлсэн, | Биелэ |
| | 4.3.4 Алтны ордыг ашигласны улмаас байгаль орчинд учруулсан хохиролын үнэлгээг Төв, Сэлэнгэ, Баянхонгор, Архангай, Өвөрхангай зэрэг аймгуудын зарим суманд Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх<br><br>Хүрэх үр дүн 4.3.4: /2017-2020/<br><br>байгаль орчинд учруулсан хохиролын үнэлгээ тодорхой болно. | БОАЖЯ-наас АМГТГ, МХЕГ, ЦЕГ-ын МБА-ны БХЖЭГХМХ-ийн холбогдох ажилтнуудыг оролцуулан Ажлын хэсэг байгуулж ажил Хяналт шалгалтад Сэлэнгэ, Дархан-Уул, Архангай, Төв, Булган, Ховд, Завхан зэрэг 8 аймгийн 20 гаруй сумын нутагт үйл ажиллагаа буй АМТЗ эзэмшиж буй 30 ААН, 20 бичил уурхай эрхлэгч, 80 гаруй хууль бусаар ашигт малтмал олборлогчид хамрагдсан Шалгалтын дүнг Засгийн газрын 2017 оны 8-р сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулан 36 тоот тэмдэглэл гарсан. Тэмд Архангай, Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарт хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг албадан буулга өгөгдсөн.Энэ ажлын хүрээнд нийт 22 ААН, 28 нөхөрлөл, 23 иргэний алт олборлож байсан үйл ажиллагааг зогсоож, 15 ААН, 8 и асуудлыг Цагдаагийн байгууллагад шалгуулахаар хүргүүлсэн. | Биелэ |
| | **4.4 Хууль бусаар алтны олборлолт явуулсан талбайн бүртгэл хийж, холбогдох этгээдийг тогтоох ажлыг улсын хэмжээгээр эрх бүхий төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах**<br><br>- Олборлолт хийсэн талбайн бүртгэлийн судалгаа хийх | "Алт-2" үндэсний хөтөлбөрийн Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу Салбар зөвлөлөөс ирүүлсэн саналыг нэгтгэж нийслэлийн засаг дарга нарт "Чиглэл өгөх, мэдээлэл хүсэх тухай" 2017 оны 2-р сарын 21-ний 01/444 тоотыг боловсруулан хүргүүлсэн. Үүний дагуу орон нутгаас ирүүлсэн 18 аймгийн мэдээлэл, судалгаа саналыг нэгтгэн судалж, хөтөлбөрийг хэрэгжүүл хэмжээнд тусган ажилласан. Үүнд тухайн орон нутагт нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбай, хууль бусаар олборлолтод өртсөн бичил уурхай эрхлэх боломжтой талбай, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх албан тушаалтан, хайгуул болон олборлолт ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн судалгаа, бичил уурхайчид, нөхөрлөлийн судалгаа, эдийн засгийн үр ашигтай ордуудыг эр оруулах, эвдэрсэн газрын тооллогыг шинэчлэн хийх зэрэг мэдээлэл, тусгах саналууд хамрагдаж АМГТГ-ын мэдээллийн санд бүр | |

| | | |
|---|---|---|
| | - Олборлолт хийсэн этгээдийг тогтоох, бүртгэлийг хийх<br><br>Хүрэх үр дүн 4.4: /2017-2020/<br><br>Судалгаа, бүртгэл хийсэн байна. | дээрх судалгаанд шүүлт хийгдэн бичил уурхай эрхлэх боломжтой, хууль бус олборлолтод өртсөн, нөхөн сэргээх шаардлагатай талбай ялгасан<br><br>Биелэлт 70%<br><br>Хугацаа болоогүй |
| | **4.5 хууль бусаар алт олборлосон талбайд нөхөн сэргээлт, хаалт хийх нөхцөл бүрдүүлэх**<br><br>- Хууль бусаар алт олборлосон, ээн орхигдсон талбайн судалгааг гаргах<br><br>- Эдгээр талбайд нөхөн сэргээлт хаалт хийх нөхцлийг бүрдүүлэх<br><br>Хүрэх үр дүн 4.5: /2017-2020/<br><br>Нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлсэн байна. Хаалтын нөхцлийг бүрдүүлсэн байна. | 18 аймгийн хэмжээнд хууль бусаар алт олборлосон, ээн орхигдсон, нөхөн сэргээх шаардлагатай талбайн судалгааг тухайн орон нутгаас гаргуулан авч мэдээллийг нэгтгэсэн.<br><br>"Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого, уурхайн хаалтын журам" сэдэвт уулзалт семинарыг 2017 оны 3-р сарын 13-14-ний өдрүүдэд Монгол-Кувейтын төвд зохион байгуулав. Семинарт БОАЖ-ын дэд сайд, ХБОБНУГ-ын дарга, УУХҮЯ, МХЕГ, АМГТГ болон 21 аймгийн БОАЖГ-ын Уул уурхайн бодлого, нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, МХГ-ын УУХАХ-сан хэлтсийн дарга зэрэг 80 гаруй албан хаагчид оролцож, уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон газрын хэмжээ, нөхөн сэргээлтийн талаар баримталж буй бодлого, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн. 2017 онд Орхон аймаг тооллогыг батлагдсан удирдамж зааврын дагуу хийж мэдээллийн санд байршуулсан. Мөн Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь зэрэг 7 аймаг урьдчилсан байдлаар хийсэн бол 2018 онд үлдсэн аймгууд 12-20 сая төгрөгийн төсөв тусгаж хийж гүйцэтгэсэн байна.<br>"Байгаль хамгаалал ба уул уурхайн нөхөн сэргээлт" үндэсний сургалт, семинар 2018 оны 10 сарын 22-23-ний өдрүүдэд зохион байгууллаа. Үндэсний сургалт, семинарт 21 аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч, БОАЖГ-ын дарга, уул уурхай хариуцсан мэргэжилтэн, УУХҮЯ, АМГТГ, МХЕГ-ын төлөөлөл, байгаль орчны мэргэжлийн байгууллагын төлөөлөл нийт 125 хүн оролцсон<br>Биелэлт 70%<br><br>Хугацаа болоогүй |
| | **4.6 Алтны үйлдвэрлэлийн улмаас тухайн уурхайн нөлөөллийн бүс нутгийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх, судлан хянах, тандах тогтолцоог бүрдүүлж алтны салбарт ажиллагсад, орон нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах**<br><br>- Алтны уурхайн нөлөөллийн бүс нутагт байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөллийг үнэлэх, судалгааг хийх<br><br>- Алтны салбарт ажиллагсад, орон нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах | Бичил уурхай бүхий аймаг, сумдын удирдлага, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын ажилтнуудын чадавхыг сайжруулах, бичил уурхайн зохион байгуулалт, албажуулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нийгмийн халамж үйлчилгээ, хүний эрх, бичил уурхайн байгаль орчны асуудлаар УУХҮЯ, АМГТГ, ЭМЯ, ХНХЯ, БОАЖЯ, ОБЕГ/УУАА, ХЭҮК, ЭМНДЕГ, ХХҮЕГ, НЭМХ, Монголбанк, Сорьцын хяналтын газар, Татварын ерөнхий газар, Монголын бичил уурхай нэгдсэн дээвэр холбоо, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд, Хэнтий, Увс аймгийн МСҮТ -тэй гэрээ байгуулан нягт хамтран ажиллаж үйл ажиллагаанд нь санхүүгийн болон мэргэжил арга зүйн хувьд дэмжлэг үзүүлж, бичил уурхайчдад үйлчилгээ хүргэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллалаа<br>ХНХЯ-ны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс бичил уурхайчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг 9-р сарын 21-22-нд Сэлэнгэ аймгийн Мандал суманд, 9-р сарын 23-нд Баянгол суманд зохион байгуулсан. Үзлэгт нийт 130 бичил уурхайчин хамрагдсан |

| | | |
|---|---|---|
| | Хүрэх үр дүн 4.6: /2017-2020/<br><br>Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөллийг үнэлэх, судлах, хянах, тандах тогтолцоог эхлүүлсэн байна | Биелэ<br><br>Хугацаа б |
| | **4.7 Хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах**<br><br>- Хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцооны судалгааг хийнэ<br><br>- Судалгааг үндэслэж, холбогдох журмын төслийг шинэчлэн боловсруулна<br><br>Хүрэх үр дүн 4.7: /2017-2018/<br><br>Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. | УУХҮ-ийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн А/48 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хороо"-г шинэчлэн байгуулсан. Хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцооны судалгааг хийх ажлыг 2017 оны са Хөдөлмөр аюулгүйн ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо"- ажиллагааны төлөвлөгөөний төсөл болон "Үндэсний 5 дахь хөтөлбөр"-ийн дагуу дэд хөтөлбөр боловсруулах ажилд Алтны са асуудлыг тусгасан.<br><br>2017 онд АМГТГ-т ирүүлсэн 94 тайланд 25244 хүн ажилласнаас 400 хүн буюу нийт ажиллагсдын 2% нь хөдөлмөрийн аюулгүй бай сургалтанд хамрагдсан байна.<br><br>Биелэ |
| | **4.8 Уурхайн хаалтын хүрээнд алт олборлолтын онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох, алт олборлосны дараа уурхайн хаалт хийгдсэн талбайд хяналт, шалгалт хийх, талбайг орон нутагт хүлээлгэн өгөх үүрэг хариуцлагыг тодорхой болгох**<br><br>- Уурхайн хаалтын зохицуулалтыг бий болгох<br><br>- Уурхайн хаалт хийгдсэн талбайд хяналт, шалгалт хийх,<br><br>- талбайг орон нутагт хүлээлгэн өгөх үүрэг хариуцлагыг тодорхой болгох<br><br>Хүрэх үр дүн 4.8: /2017-2020/ | "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын төслийг боловсруулах Дэд ажлын хэсгийг БОАЖЯ, АМГТГ болон судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, журмын т талаар санал солилцсон. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийж, вэб төслийг байршуулан олон нийтийн саналыг авах ажлыг зохион байгуулсан. Журмын төсөлд санал авахаар БОАЖЯ-нд 2017 оны 05 сарын 22-ны өдөр 01/1166 албан тоотоор хүргүүлсэн ба БОАЖЯ-наас СЕСМИМ төслийн хийж байгаа судалгааны дүгнэлт, санал га мөн "Уул уурхайн тухай" хууль батлах хүртэл энэхүү журмыг хойшлуулах гэсэн санал ирүүлсэн.<br><br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2018 оны 11-р сарын 20-ны өдрийн бичил уурхайн нөхөн сэргээлтийг аргачлалын дагуу хийсэн бай танилцах а/572 тоот тушаал батлагдсан. Энэхүү тушаалын удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн Хайрхандулаан, Нарийн тээл "Хиймори йн хишиг", "Баянхангай" нөхөрлөлийн алт олборлох талаар гаргасан хүсэлт, байгуулсан гэрээ зэрэг холбогдох баримт би танилцаж газар дээр нь үзэж танилцсан. Бичил уурхайчдын алт ашиглах явцад эвдсэн газар, түүнийг аргачлалын дагуу нөхөн сэр байдалтай танилцахад эдгээр нөхөрлөлийг байгуулахдаа ах дүүгийн хамааралгүй иргэдийг оролцуулсан, бичиг баримтын бүрд бүрэн хангасан, зөвхөн эвдэгдсэн эзэнгүй талбайд хуурай технологиор ажиллуулж нөхөн сэргээх газрыг тухай бүрт нь шалгаж н үлдэгдэлгүй болсныг бүрэн нөхөн сэргээсэн байна.<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/88 тоот тушаалаар "Уурхай, уулын болон бая үйлдвэрийн хаалтын нөхөн сэргээлтийн журам" боловсруулах ажлын байгуулагдан ажилласан. Журмын төсөл 2 удаагийн олон н хэлэлцүүлэг хийгдэж Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас санал авч нэгтгэгдэн Уул у хүнд үйлдвэрийн болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлагдах бэлтгэл ажлыг хангаан аж байна.<br><br>БОАЖЯ-аас Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Сэврэй сумын Баян бор нуруунд ний га талбайд нөхөн сэргээлт хийж ГГСХЗ-нд хүлээлгэн өгсөн. Баянхонгор аймгийн Овоон шанд гэдэг газарт 3 га газарт нөхөн сэргээл Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн. |

| | | |
|---|---|---|
| | Уурхайн хаалт хийгдсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгөх үүрэг хариуцлагыг тодорхой болгосон байна. | Биелэлт 70%<br><br>Хугацаа болоогүй |
| | 5-р зорилтын хүрээнд:<br><br>**5.1 Бичил уурхайгаар алт олборлоход ашиглаж байгаа техникийн стандартыг боловсронгуй болгох, хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах болон борлуулах албан ёсны сүлжээ бий болгох**<br><br>- Алтны бичил уурхай эрхлэлтийн судалгааг нарийвчлан гаргах<br><br>- Судалгаанд үндэслэж холбогдох журамд өөрчлөлт оруулах<br><br>Хүрэх үр дүн 5.1: /2017-2018/<br><br>алтны бичил уурхайд ашиглаж байгаа техникийн стандартыг сайжруулсан байна<br><br>**5.2 Бичил уурхай эрхлэх талбайг улсын хэмжээнд нарийвчлан тогтоож, бүртгэж байх**<br><br>- Бичил уурхай эрхлэх талбайн судалгааг гаргах<br><br>- Судалгаанд үндэслэж талбайг тогтоох<br><br>Хүрэх үр дүн 5.2: /2017-2018/<br><br>Бичил уурхай эрхлэх талбайг тогтоосон байна. | 5-р зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулагдсан Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг ажилласан. УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг бичил уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн болон хууль бус олборлолтын үйл явагдаж байгаа Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал, Төв аймгийн Заамар суманд очиж, томилолтоор ажилласан.<br>Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн боловсруулж, 2017оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор батлуулсан. Энэхүү журмаар бичил уурхайгаар ашиглах техникийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, хувиараа ашигт малтмал олборлох хууль бус үйл ажиллагааг бичил уурхайн зохион байгуулалтад оруулах, албажуулах, байгаль орчны хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 13 аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажилласан.<br><br>Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал боловсруулах, түүнийг турших үзсэний үндсэн дээр аргачлалыг 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан дугаар А/226, А/182 тушаалаар батлагдсан.<br>Алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах талаар Монголбанк, Үнэт металлын сорьцын хяналтын газар, Татварын ерөнхий газар, орон нутгийн удирдлагууд, бичил уурхайчид зэрэг холбогдох талуудтай хамтарч ажилласан.<br><br>2018 оны 3-р сарын 1-нд Бичил уурхайн Мэдлэгийн төвийг нээж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүлээлгэн өгсөн. Тус яамны Бодлогын хэрэгжилтийн газрын хоёр мэргэжилтэн Мэдлэгийн төвийн үйл ажиллагаа, ажлын албыг хариуцан ажиллаж байна<br>Биелэлт 100%<br><br>Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг тухайн орон нутгаас авч нэгдсэн дүнг гаргасан.Бичил уурхай эрхлэх талбайн судалгааг аймгуудаас хүлээж аван саналыг нэгтгэн холбогдох байгууллагаар хянуулан бичил уурхай эрхлэх боломжтой 6 аймгийн нутаг дэвсгэрт нийт 18 талбайг ялгасан.<br><br>"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын дагуу бичил уурхайн талбайн дүгнэлт гарсан 18 аймгийн Засаг дарга нарт бичил уурхайн мэдээ ирүүлэх тухай 2018 оны 1 сарын 15-ны өдөр 5/296 тоот албан бичиг хүргүүлж Дорнод, Орхон, Баян-Өлгий, Булган, Хэнтий, Төв, Говь-Алтай, Завхан, Дархан-Уул аймгаас ирсэн бичил уурхайн мэдээг мэдээллийн санд нэгтгэв.<br>УУХҮ-ийн сайдын 2018 оны 8 сарын 15-ны өдрийн 04 тоот албан даалгавар гарсны дагуу Веб газарзүйн мэдээллийн системд суурилсан Бичил уурхайн мэдээллийн сан бий болгох ажилд ТББ-тай хамтран ажиллаж байна.<br>АМГТГ-ын УУҮТХ-ийн бичил уурхайн асуудал хариуцсан баг төслийн дэмжлэгтэйгээр 2018 онд Ховд аймгийн Алтай, Мөст, Цэцэг сум, Дундговь аймгийн Хулд, Луус, Өлзийт сум, Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Баян-овоо, Жаргалант, Галуут сум, Баян-Өлгий аймгийн Ногоон нуур, Алтанцөгц, Цэнгэл сум, Төв аймгийн Заамар, Баян, Баян-Чандмань, Бор-Нуур, Баян, Жаргалант сум, Булган аймгийн Бүрэгхангай сум, Говь-сүмбэр аймгийн Сүмбэр, Говь-Алтай аймгийн Алтай, Есөнбулаг, Тайшир, Цээл сумд, Өвөрхангай аймгийн Уянга сум, Завхан аймгийн Ургамал, Дөрвөлжин сум Увс аймгийн Наранбулаг сум, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал, Ерөө, Хүдэр сум, Дархан-Уул аймгийн Дархан, Шарынгол, Хонгор сум, Орхон аймгийн Баян-Өндөр, Хэнтий аймгийн |

| | | |
|---|---|---|
| | | Цэнхэрмандал, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Овоо, Норовлин, Батноров, Галшар, Дархан, Бор-Өндөр, аймгийн Баян-уул, Баяндун, Дашбалбар, Гурванзагал, Чойбалсан, Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар, Ү Түвшинширээ, Мөнххаан сум, Архангай аймгийн Цэнхэр сумдын нийт 19 аймгийн 62 сумдын 212 нэгж талбай дээр тус тус нутаг томилолтоор ажиллажээ. Томилолтоор ажиллах явцад ХАМО иргэдийн үйл ажиллагаа явуулж буй талбайн давхцалыг шалган уурхайн талбайн дүгнэлт гарах үйл явц, хууль, журмын талаар нийт 9,875 иргэнд мэдээлэл өгч, ашиглалт, аюулгүй байдал сэргээлтийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн ХАМО иргэдийн үйл ажиллагаа явуулж буй талбайн солбицлыг тогтоон т зургийг дрон ашиглан дүрсжүүлсэн байна.<br><br>Биелэлт |
| | **5.3 Бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, нөхөрлөлийг чадавхижуулж бүртгэх замаар цаашид хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хүн амын орлогын болон бусад татвар, төлбөр, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох**<br><br>- Бичил уурхай эрхлэгчдийн бүртгэл, олборлолтын талаарх судалгааг хийх<br><br>- Судалгааг үндэслэж татвар, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох<br><br>Хүрэх үр дүн 5.3: /2017-2018/<br><br>нөхөрлөлийг чадавхижуулж аж ахуйн нэгж болгох ажлыг эхлүүлсэн байна. | Увс аймгийн Улаангом Политехник Коллеж, Дархан-Уул аймгийн Уул уурхай, эрчим хүчний политехник коллеж болон Ховд а Хөгжил политехник коллежуудтай хамтран нийт 125 бичил уурхайчныг цахилгаанчин, баяжуулалтын оператор, ХАБ-ын ажилта машин механизмын оператор, тогооч, гуталчин, оёдолчин, автомашины засварчин гэх мэт мэргэжлүүдээр богино хугацааны сур хамруулан, чадамжийн гэрчилгээ олгогдсон. Эдгээрээс нийт 30 бичил уурхайчин ажил мэргэжилтэй болсны үр дүнд бичил уурхайг чиглэлээр орлогын эх үүсвэрээ төрөлжүүлсэн. Үүнд 21 нь хувиараа эсвэл орон нутгийн жижиг дунд зээлд хамрагдан оёдлын цех, цех, ногооны хүлэмж зэрэг бизнес эрхэлж байгаа бөгөөд 9 бичил уурхайчин Дархан-Уул аймгийн Болд Төмөр Ерөө Гол ХХК-д төхөөрөмжийн операторчноор ажиллаж байна.<br>Орон нутгаас бичил уурхай эрхлэгчдийн судалгаа гаргуулж авсан. Бичил уурхайчдыг орлогын өөр эх үүсвэртэй болгох зорилгоор бизнесийн төсөл боловсруулах сургалтуудад бичил уурхайчдыг хамруулж жижиг зээл олгох ажлыг санхүүгийн байгууллагуудтай х зохион байгууллаа. Мөн бичил уурхайгаас өөр ажлын байранд шилжих, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай болс дэмжлэг үзүүлэх зорилгоор 85 бичил уурхайчныг Увс, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотод мэргэжил сургалт үйлдвэрлэлий сургасан. Увс аймгийн Улаангом политехник коллежтой хамтран 5 бичил уурхайчныг "Талх, нарийн боовны дадлагын газар"-т 1 хугацаатай бойжуулж бие даан ажиллаж, бүтээгдэхүүний төрлөө нэмэх чадамжтай болгож, төгсгөсөн. Мөн 5 бичил уурхайчныг "С инкубаци" төвд 3-н сар бойжуулж хувиараа захиалгат оёдол хийх, бүтээгдэхүүнийхээ төрлийг нэмэх чадамжтай болгож, амж төгссөн. Эдгээрээс 5 бичил уурхайчин эмэгтэй МБУНДХ болон Канад Сангийн хамтран хэрэгжүүлж буй жижиг төслөөс санхүүжи Увс аймгийн Бичил уурхайчдын нэгдсэн холбооны дэргэд оёдлын цех нээн ажиллуулж байна.<br><br>Биелэлт |
| | **5.4 Алтны ордуудыг ашиглах явцад үүссэн хаягдал нөөцийг бүртгэлжүүлж, үнэлгээ хийх**<br><br>-Үүсмэл ордын нөөцийг бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлнэ.<br>1.1 Үүсмэл ордын байршил, нөөцийн судалгааг гаргах<br>1.2 Үүсмэл орд ашиглах үнэлгээ хийх | "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам", "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд та шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төслийг боловсруулсан.<br><br>"Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажилл тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төсөлд бүх яамдын саналыг нэгтгэн тусгаж, Засгийн газрын 2017 оны 02 дугаар 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан. "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгж хангах зорилгоор УУХҮ-ийн сайдын 2017 оны А/93 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулж, дээрх 2 журмын хэрэгжилтийг хангах зохион байгуулсан. |

| | | |
|---|---|---|
| | - Үүсмэл орд ашиглах журмыг боловсруулна<br><br>- Үүсмэл ордын нөөцийг тогтоох аргачлалыг боловсруулах<br><br>Хүрэх үр дүн 5.4: /2017-2018/<br><br>Хаягдал нөөцийн судалгаа хийгдэж, нөөцийн үнэлгээ хийгдсэн байна. | Биелэлт 90% |
| | **5.5 Бичил уурхай эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник хангамж болон нөхөн сэргээлтийн талаар сургалт явуулах**<br><br>- Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник хангамж болон нөхөн сэргээлтийн талаар сургалтыг улсын хэмжээнд явуулах.<br><br>- Сургалтыг тухайн орон нутагт явуулах<br><br>Хүрэх үр дүн 5.5: /2017-2018/<br><br>Тухай бүр сургалтыг явуулсан байна. | Швейцарын хөгжлийн агентлагын хэрэгжүүлж байгаа "Тогтвортой бичил уурхай төсөл"-ийн хөрөнгөөр аймгуудад бүсчилсэн болон Улаанбаатар хотод төвлөрсөн сургалтыг зохион байгуулж, аймгуудын ЗДТГ, агентлагийн ажилтнууд, бичил уурхайчдыг хамруулсан. Энэ ажлын хүрээнд "Бичил уурхайн эрх зүйн орчны шинэчлэл" сэдэвт 4 бүсийн сургалт болон "Хариуцлагатай бичил уурхайн төлөө хамтдаа" Үндэсний чуулганыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. 2017 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар байдлаар төслийн хэрэгжилтийн хүрээнд хамтрагч байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, семинар, арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 30,117 хүн оролцсон байна. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу Баянхонгор аймгийн Галуут сумын Шар хуруу нэртэй газар 5 га, Баян-Овоо сумын Цагаан цахирт нэртэй газар 3.5 га, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Рашаантын шил 1 га, Баяншанд жамбий 3.8 га, Зүрх толгойн урьд салаа 6.2 га нийт 11 га, Ховд аймгийн Алтай сумын Бодончийн хөндлөнгийн Тамт нэртэй газар 5 га, Увс аймгийн Хяргас Түргэн, Өмнөговь, Тариалан сумдад нийт 8 га, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Могойн гол нэртэй газар 5 га эвдэрсэн талбайд нийт 37.5 га талбайд тухайн орон нутгийн бичил уурхайн 10 ТББ-уудын оролцоотойгоор нөхөн сэргээлт хийлээ. Нөхөн сэргээлтэд орон нутгийн төсвөөс 29.5 сая, бичил уурхайн байгууллагуудаас 17.0 сая төгрөгийн хамтарсан санхүүжилт оруулсан бөгөөд төслөөс 100 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын сургалтыг Сэлэнгэ аймгийн Ерөө, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Увс аймгийн Хяргас, Түргэн сумдад зохион байгуулж нийт 98 иргэд хамрагджээ.<br>"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцаа ба бичил уурхай" сэдвээр аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2018 оны 5 сарын 24, 25-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгууллаа. Сургалтад 18 аймаг болон сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны асуудал хариуцсан 50 мэргэжилтэн хамрагдлаа<br><br>Дархан-Уул аймгийн Уул уурхай, эрчим хүчний политехник коллеж болон Ховд аймгийн Хөгжил политехник коллежуудтай хамтран Ховд, Дархан, Сэлэнгэ аймгуудын бичил уурхай бүхий сумдаар аялан, нийт 277 бичил уурхайчдад ХАБ-ын анхан шатны сургалтыг зохион байгуулсан.<br><br>Биелэлт 100% |
| | **5.6 Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж орхигдсон талбайд байгаа үүсмэл ордуудыг ашиглах үйл ажиллагаанд** | Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Нарийн хөтөл нэртэй газар 4 га талбайд "Вантайж" ТББ, Жамбий нэртэй газар 4 га талбайд "Олон зангилаа" нөхөрлөл, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Цагаан цахирт нэртэй газар 4 га талбайд "ХАМОДХ" ТББ, Галуут сумын Нурамт, Балгантын Хадан карьер нэртэй газар 5 га талбайд "Батсайхан сэтгэл" ТББ-ын гишүүн бичил уурхай эрхлэгчид хамтарсан санхүүжилтээр орхигдсон эвдэрсэн газрыг бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нийт 17 га талбайг нөхөн сэргээн аймаг сумын Засаг даргын томилсон комисст 11 сард хүлээлгэн өгсөн. |

| | | |
|---|---|---|
| | **орон нутгийн нөхөрлөлийг оролцуулахад дэмжлэг үзүүлэх**<br>- Талбайн судалгааг хийж үүсмэл ордын хэсгийг бүртгэх<br>- Бүртгэсэн талбайд нөхөрлөл оруулах асуудлыг шийдвэрлэх<br>Хүрэх үр дүн 5.6: /2017-2018/<br>Үүсмэл ордыг ашиглахад хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлсэн байна. | Баян-Өлгий аймаг - 1 талбай, Дундговь аймаг - 2 талбай, Баянхонгор аймаг - 42 талбай, Сэлэнгэ аймаг - 25 талбайг аймгийн И төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоолоор бичил уурхайн зориулалтаар газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч А хүргүүлэн кадастр, зураг зүйн системд бүртгүүлэх, дүгнэлт гаргуулах ажлууд хийгдсэн байна. Одоогийн байдлаар Баян-Өлгий а Цэнгэл сумын Хавцал нэртэй газар 5 га талбайд АМГТГ-аас дүгнэлт гарч сумын Засаг дарга бичил уурхайн нөхөрлөлтэй гэрээ ба алтны шороон ордод бичил уурхайчид үйл ажиллагаа явуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Бусад аймгууд хүлээгдэж байна.<br>Биелэлт |
| 7. | Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд) | Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал, дутагдалтай талуудыг бичнэ.<br>“Алт-2” үндэсний хөтөлбөр нь УИХ-аас батлан гаргасан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт б тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд Засгийн газрын Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дах алт үйлдвэр салбарын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэгдсэн зорилтот ууган баримт бичиг болсон.<br>Хөтөлбөрт төлөвлөгдсөн нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр ЗГХЭГ, УУХҮЯ, Монголбанк, СЯ, БОАЖЯ,орон н захиргаад, ЦЕГ, Мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллага, алт олборлогч аж ахуйн нэгжүүд хамтран ажилласан. Монголба “Алт” аяныг санаачлан зарлан жил дараалан хамтран зохион байгуулсны үр дүнд хөтөлбөрийн үндсэн үзүүлэлтийн алт олборл төлөвлөгөө биелж 2017 онд 2,0 тн-р давж 20 тн-д, 2018 онд Монголбанкинд тушаагдсан алтны хэмжээ 21.9 тн-д хүрсэн.<br>Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хөдөө орон нутагт хууль бус олборлолт ихэсч байгаль орчныг эвдлэн сүйтгэх, эвдэрсэн з газрын тоо нэмэгдэж тухайн орон нутгаас тэдгээрийг таслан зогсооход дорвитой арга хэмжээг авч чадахгүй байна. Иймд алтны хуу олборлолтыг орон нутагт таслан зогсооход хяналтыг сайжруулж, холбогдох төрийн захиргааны мэргэжлийн ,хууль хүчний байгу иргэдийн оролцоог хангаж ажиллах шаардлагатай байна. |
| 8. | Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад УУХҮЯ, Монголбанк, БОАЖЯ нягт хамтран ажилласан. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | | Биелэлт дундаж | Зорилтын тоо | Зорилт 1 | Зорилт 2 | Зорилт 3 | Зорилт 4 | Зорилт 5 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ) | 71.16 % | 43 | 12<br>77.5 % | 5<br>76% | 12<br>65.8% | 8<br>52.5 | 6<br>90 |
| 10. | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ<br>(ЗГХЭГ-ын үнэлгээ) | | | Нэгдсэн үнэлгээ<br>... % | | | | |
| | | | | | | | | |

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү

Хяналт шинжилгээ, үнэлгээ /ХШҮ/ хийсэн:

ХШҮДАГ-ын мэргэжилтэн Д.Батнайрамдал

Тайланг нэгтгэсэн ГУУБХЗГ-ын Геологийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Мөнхцэнгэл

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН

## З А Х И Р А М Ж

2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 17 | Улаанбаатар хот

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

1. “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга -Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж

Гишүүд: -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Даажамба;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Нямаа;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Д.Даваасамба;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга Д.Ганбат.

Нарийн бичгийн дарга -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мандахбат.

2. Зөвлөлийн ажиллах журмыг баталж, үйл ажиллагааг нь шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Зөвлөл (Ц.Дашдорж)-д, Зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.ЭРДЭНЭБАТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.ДАШДОРЖ

| | | |
|---|---|---|
| | | хүсэлтийн дагуу холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч 2018.10.19-ний өдрийн 2/1830 албан бичгээр хариуг хүргүүлэн ажилласан. |
| 3.2.8 | Аймгийн нутаг дэсвгэрт ашигт малтмал, газрын тосны эрэл, хайгуул, олборлолт, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаж байгаа бол Ашигт малтмал, газрын тосны газар, гэрээлэгч компаниудтай зохион байгуулах уулзалтад идэвхтэй оролцох, хамтран зохион байгуулах | Дорноговь аймаг уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд 2016 оноос эхлэн "Хариуцлагатай уул уурхай-Хамтын ажиллагаа" сэдэвт уул уурхайн зөвлөгөөнийг 3 дахь жилдээ буюу 1-р сард Сайншанд хотод зохион байгуулж, 3-р сард уул уурхайн ашиглалтын 56 аж ахуйн нэгжтэй "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулсан нь урьд оноос 8 ААН-ээр нэмэгдсэн.<br><br>Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл болон "Монголын бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбоо" ТББ-тай хамтран Дорноговь аймгийн бичил уурхайдын өдөрлөг, хэлэлцүүлгийг 2018.11.29-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөг хэлэлцүүлэгт бичил уурхайтай 5 сумын Засаг дарга болон БОХУБ, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар, БОАЖГазруудаас мэдээлэл хийж, нөхөрлөлийн төлөөллүүд 30 гаруй иргэн оролцож байгаль орчинд хал багатай бичил уурхайн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, оролцогч талуудын хариуцлагатай бичил уурхайн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх талаар хэлэлцлээ. |
| 3.2.9 | Орон нутагт газар олголтыг зохион байгуулахдаа хүнд үйлдвэр байгуулах боломжит байршлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газар олгох, шаардлагатай тохиолдолд газрыг тусгай хэрэгцээнд авах асуудлаар холбогдох хууль, журмын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах | Уул уурхайн томоохон үйлдвэрүүдтэй сумд болох Айраг, Даланжаргалан, Өргөн сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 71250.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Шинэ хотжилт" ХХК гүйцэтгэхээр 2011 онд гэрээ байгуулж эхлүүлсэн боловч бүрэн дуусгаж хүлээлгэн өгөөгүй байна.<br><br>Дээрх сумдын ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх талаар тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн компаниудад хандсан боловч өмнө хийгдсэн суурь судалгаанаас хойш 5 жил өнгөрсөн, хүн ам, үйлдвэрлэл нэмэгдсэн шалтгааны улмаас зайлшгүй шинээр төлөвлөлт хийх шаардлагатай гэсэн хариуг өгсөн. 2019 оны төсөвт шаардлагатай хөрөнгийг тусгуулахаар ажиллаж байна.<br><br>Аймгийн ИТХ-ын 2018.05.07-ны өдрийн 08/03 дугаар тогтоолоор Эрдэнэ сумын нутаг Хунхат нэртэй газрын 50 га талбайг бичил уурхайн зориулалтаар |

Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолын хавсралт

# “АЛТ-2” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

## Нэг. Нийтлэг үндэслэл

### 1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Засгийн газрын 1991 оны 304 дүгээр тогтоолоор анх баталсан “Алт хөтөлбөр” болон “Алт-2000 хөтөлбөр”-ийг 1992-2000 онуудад хэрэгжүүлсний үр дүнд улсын хэмжээнд алтны олборлолт, экспорт эрчимтэй өсч, улсын төсвийн орлого болон гадаад валютын нөөц нэмэгдэж, тухайн үеийн эдийн засгийн хямралыг даван туулахад чухал хувь нэмрийг оруулсан болно.

Үндэсний статистикийн хорооны 2015 оны 10 дугаар сарын мэдээгээр алтны үйлдвэрлэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувь, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн 9.6 хувь, экспортын орлогын 9.1 хувийг эзэлж байгаа нь алтны үйлдвэрлэл Монгол Улсын эдийн засагт ихээхэн нөлөөтэй болохыг харуулж байна.

Хэдийгээр алт олборлолт манай улсын эдийн засагт нэг талаас эерэг нөлөө үзүүлсэн боловч нөгөө талаас далд эдийн засаг бий болох, байгаль орчныг бохирдуулах, нөхөн сэргээлтийг хангалтгүй хийх, хууль бусаар алт олборлох зэрэг тулгамдсан асуудал бий болсон.

Өмнө хэрэгжүүлсэн алт хөтөлбөрүүдийн эерэг үр дүн, сургамж болон уул уурхайн салбарт 2014-2015 онд бий болсон татвар, хууль эрх зүйн таатай орчинд тулгуурлан алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, алтны үйлдвэрлэлийн талаар Засгийн газраас баримтлах цаашдын зорилго, зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх замаар улс эх орны эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийг хангах зорилтууд тусгагдсан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

### 1.2. Хөтөлбөрийн хамрах хүрээ

““Алт-2” үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хамруулж хэрэгжүүлнэ:

1.2.1. алтны чиглэлээр геологийн судалгаа, эрэл, хайгуул хийх, алт олборлох, боловсруулах, борлуулах, экспортод гаргах;

1.2.2. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайн хаалт болон эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бичил уурхай эрхлэх.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

### 2.1. Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхийг өсгөхөд энэхүү үндэсний хөтөлбөрийн гол зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх;

2.2.2. геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулах;

2.2.3. алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник, технологийг сайжруулж шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх;

2.2.4. алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчныг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох;

2.2.5. бичил уурхайгаар алт олборлох, борлуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

Хөтөлбөрийг ойрын болон дунд хугацааны 2 үе шаттайгаар 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат буюу ойрын хугацаанд (2017-2018 он): Алтны үйлдвэрлэлтэй холбоотой харилцаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр алтны олборлолтыг нэмэгдүүлэх, бэлтгэгдсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг цэгцлэх ажлыг эхлүүлнэ.

Хоёрдугаар үе шат буюу дунд хугацаанд (2019-2020 он): Алтны эрэл хайгуул хийх болон олборлох, үйлдвэрлэхэд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж алтны олборлолт, үйлдвэрлэлийг тогтвортой өсгөх, байгаль орчин, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

**3.1. "Хөтөлбөрийн хүрээнд татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх" зорилтын хүрээнд:**

3.1.1. алтны үйлдвэрлэлийн татварын орчин, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судалж, олон улсын чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд орон нутгаас тавьдаг шаардлагыг

хуулийн хүрээнд тодорхой болгох, алтны үйлдвэрлэлийн салбарын хүрээнд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй болгох;

3.1.3. алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журмыг шинэчлэн боловсруулж мөрдөх;

3.1.4. алт олборлох болон баяжуулах, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах технологийн шаардлага, олборлолтын үеийн металл авалтын нормативт хязгаарыг тогтоож, холбогдох стандартыг боловсруулж мөрдүүлэх;

3.1.5. алтны зах зээл дэх эрэлт, хэрэгцээ, үнийн дунд хугацааны төсөөллийг тодорхойлох, алтны олборлолт, борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөх;

3.1.6. алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, алт олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж олборлосон алтыг худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор зээл олгох хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлж хэрэгжүүлэх;

3.1.7. алтны олборлолтын ажил төвлөрөн явагдаж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт бүхий бүсийг тогтоон алтны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг иж бүрэн цогцоор нь хэрэгжүүлэх ;

3.1.8. хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоохтой холбоотой эрх зүйн орчинг сайжруулах;

3.1.9. зэс болон бусад металлын баяжмал дахь үнэт металлыг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг татварын болон хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих;

3.1.10. “Алтны бирж” байгуулах боломжийг судалж, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.1.11. алтыг орон нутагт худалдан авах үйл ажиллагааг Монголбанкны салбар болон арилжааны банкаар гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх;

3.1.12. бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх болон сорьц тогтоох үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмыг шинээр боловсруулан мөрдүүлэх.

3.2. **Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулах зорилтын хүрээнд:**

3.2.1. алтны хэтийн төлөв бүхий бүс нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн болон алтны сэдэвчилсэн судалгаа, ерөнхий эрлийн ажлыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилийн улсын төсвийн төсөлд тусгуулан хэрэгжүүлэх;

3.2.2. улсын алтжилт бүхий өмнөд хил орчмын бүс, зарим тусгай хамгаалалттай газар нутагт геологийн судалгааг явуулж үнэлгээ өгөх, цаашдын чиглэлийг тодорхойлох;

3.2.3. алтны эрэл хайгуулын болон геологийн зураглалын ажилд олон улсад нэвтэрсэн дэвшилтэт техник, технологийг Монгол Улсад нутагшуулах, хайгуулын ажлын арга зүй, түүнд тавигдах шаардлагыг шинэчилж мөрдүүлэх;

3.2.4. алтны хэтийн төлөв бүхий талбайд сонгон шалгаруулалтын

журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг тэргүүн ээлжинд зохион байгуулах;

3.2.5. алтны нөөцийн бүртгэл, эрэл хайгуулын ажлын мэдээллийг тогтмол шинэчлэн, нөөц хөдөлгөөнийг жил бүр хийж баталгаажуулах.

**3.3. Алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник, технологийг сайжруулж шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх,нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх зорилтын хүрээнд:**

3.3.1. алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.2. хариуцлагатай ил тод уул уурхайг хөгжүүлэх, олон улсын туршлага, алтны эдийн засгийн үр өгөөж, орон нутгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмэр, алтны борлуулалтаас олох орлогын зарцуулалтын талаар олон нийтэд сурталчлан ойлгуулахад чиглэсэн мэдлэг, боловсрол олгох сургалт зохион байгуулах;

3.3.3. ойролцоо болон хил залгаа орших тусгай зөвшөөрөл бүхий алтны ордуудын ашиглалтын үеийн тосгон, дэд бүтэц, зам, цахилгаан хангамж болон алт боловсруулах үйлдвэрийг цогц байдлаар төлөвлөн байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх;

3.3.4. стратегийн ач холбогдол бүхий алтны ордуудын ашиглалтыг эхлүүлэх;

3.3.5 алтны болон алт агуулсан бусад ашигт малтмалын ордуудад судалгаа хийж, үнэлгээ өгөх замаар эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай нөхцөлийг тодорхойлсны үндсэн дээр зохих дэмжлэг үзүүлэх;

3.3.6. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хүрээнд шороон болон үндсэн ордыг цаашид зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.7. Үнэт металлын сорьцын хяналтын байгууллагыг бэхжүүлж техник технологийг шинэчлэх, алт олборлолтын томоохон бүс нутагт сорьцын салбар лаборатори байгуулах нөхцөлийг хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах;

3.3.8. алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах;

3.3.9. алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

3.3.10. дэлхийн алтны олборлолт, худалдаа, олон улсын зах зээлийн үнэ, Монголбанкны сар бүрийн алтны худалдан авалтын тухай мэдээллийн нэгдсэн сан бий болгох;

3.3.11. алтны олборлолт, боловсруулалт, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын үйл ажиллагааг стандартын түвшинд гүйцэтгэж, Монголбанкинд алт тушаасан үндэсний компанийн үйл ажиллагаанд зохих дэмжлэг үзүүлэх;

3.3.12. алтны үйлдвэрлэлд ажиллагсдын чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа алт олборлогч аж ахуйн нэгж, ажиллах хүчний судалгааг хийж урамшууллын механизмыг бий болгох.

**3.4. Алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчинг хамгаалах болон**

**үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд:**

3.4.1. алтны үйлдвэрлэлийн улмаас эвдрэлд орсон талбайн бүртгэл тооллого болон нарийвчилсан байр зүйн зураглал хийж, хохирлын хэмжээг тогтоосны үндсэн дээр нөхөн сэргээлт хийх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан буруутай хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх замаар алт олборлогч аж ахуйн нэгжийн хариуцлагыг өндөржүүлэх, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

3.4.2. алт олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлж, тэдгээрт тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгох, төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх;

3.4.3. алтны орд ашигласны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн үнэлгээг тодорхойлох олон улсын туршлагыг судлан холбогдох аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх;

3.4.4. хууль бусаар алт олборлолтод өртсөн талбайн бүртгэл хийж, эрх бүхий төрийн байгууллагатай хамтран хууль бусаар алт олборлосон этгээдийг тогтоож, хариуцлага тооцон хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

3.4.5. хууль бусаар алт олборлосон талбайд нөхөн сэргээлт, хаалт хийх нөхцөл бүрдүүлэх;

3.4.6. алтны үйлдвэрлэлийн улмаас тухайн уурхайн нөлөөллийн бүс нутгийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх, судлан хянах, тандах тогтолцоог бүрдүүлж алтны салбарт ажиллагсад, орон нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах;

3.4.7. хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах;

3.4.8. уурхайн хаалтын хүрээнд алт олборлолтын онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох, алт олборлосны дараа уурхайн хаалт хийгдсэн талбайд хяналт шалгалт хийх, талбайг тухайн орон нутагт хүлээлгэн өгөх журмыг тодорхой болгох.

**3.5. бичил уурхайгаар алт олборлох, борлуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилтын хүрээнд;**

3.5.1. бичил уурхайгаар алт олборлоход ашиглаж байгаа техникийн стандартыг боловсронгуй болгох, хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах болон борлуулах албан ёсны сүлжээ бий болгох;

3.5.2. бичил уурхай эрхлэх талбайг улсын хэмжээнд нарийвчлан тогтоож, бүртгэж байх;

3.5.3. бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, нөхөрлөлийг чадавхижуулж бүртгэх замаар цаашид хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хүн амын орлогын болон бусад татвар, төлбөр, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох;

3.5.4. алтны ордыг ашиглах явцад үүссэн хаягдал нөөцийг бүртгэлжүүлж, үнэлгээ хийх;

3.5.5 бичил уурхай эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник хангамж болон нөхөн сэргээлтийн талаар сургалт явуулах;

3.5.6. тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж орхигдсон талбайд байгаа үүсмэл ордуудыг ашиглах үйл ажиллагаанд орон нутгийн нөхөрлөлийг оролцуулахад дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1. "Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна:

4.1.1. алт олборлолт, үйлдвэрлэл болон борлуулалттай холбоотой эрх зүй, татварын тогтвортой орчин бүрдэж, алтны хайгуул болон олборлолтын салбарт хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна;

4.1.2. алтны ордуудын нөөцийн үнэлгээ, нөөцийн хөдөлгөөний бүртгэл шинэчлэгдэж, түүнийг тогтмол баяжуулан хөтөлдөг болсон байна;

4.1.3. хөтөлбөр хэрэгжих хугацаанд гүйцэтгэсэн эрэл хайгуулын ажлын үр дүнд Монгол Улсын алтны нөөц 100-150.0 тонноор нэмэгдсэн байна;

4.1.4. алтны олборлолтын хэмжээг жилд 2-3 тонноор нэмэгдүүлж, улмаар 2020 онд 25 тоннд хүргэсэн байна;

4.1.5. алтны хяналт хариуцлагын тогтолцоо төлөвшин бүрдсэн байна;

4.1.6. алтны олборлолт, боловсруулалт, хүний эрүүл мэнд, байгаль орчин, уурхайн хаалтын менежментийн дэвшилтэт техник, технологи, аргачлал, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлж, алтны хаягдлыг багасган алтны уурхайн талбайг стандартын дагуу нөхөн сэргээж, уурхайн хаалтыг хийдэг болсон байна;

4.1.7. алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулагдсанаар бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд шууд борлуулах боломж бүрдэхийн зэрэгцээ үнэт металлын эцсийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрлэл хөгжиж, шинээр ажлын байр бий болсон байна;

4.1.8. Монголбанкинд тушаах алтны хэмжээ тогтвортой өсч, гадаад валютын нөөц нэмэгдсэнээр үндэсний валютын ханш тогтворжиж, Монгол Улсын зээлжих зэрэглэл, төлбөрийн чадвар сайжирсан байна;

4.1.9. бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, татвар ногдуулах оновчтой тогтолцоонд шилжсэнээр улсын болон орон нутгийн төсөвт оруулах орлого нэмэгдсэн байна.

4.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

4.2.1. хууль тогтоомж, тогтолцоо, зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт;

4.2.2. алтны нөөцийн өсөлт;

4.2.3. металл авалтын нэмэгдэл, алт цэвэршүүлэх нөхцөлийн бүрдэлт;

4.2.4. алтны ордуудын иж бүрэн ашиглалт;

4.2.5. алтны уурхайн хаалттай холбоотой эрх зүйн зохицуулалт .

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1. аж ахуйн нэгж, бичил уурхайчдын нөхөрлөлийн өөрийн хөрөнгө оруулалт;

5.2. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

4.2.6. гадаад болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт;

4.2.7. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

4.2.8. зээл болон бондын эх үүсвэр;

4.2.9. Монголбанк болон Хөгжлийн банкны эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. "Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөлийг уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр ахлуулан байгуулна. Зөвлөл нь "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэгтэй байна.

9.2. "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

oOo

Хавсралт 5

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД, САНГИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 6 сарын 14-ны өдөр | Дугаар А/202/А/174/А-185 | Улаанбаатар хот
---|---|---

Алт-2 үндэсний хөтөлбөрийн
ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алт-2 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Нямаа/, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Нандинжаргал/, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ш.Цэнгэл/, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч нарт тус тус даалгасугай.

| УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД | САНГИЙН САЙД | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ |
|---|---|---|---|
| Ц.ДАШДОРЖ | Б.ЧОЙЖИЛСҮРЭН | Д.СЭРЭНХОВОЛ | Н.БАЯРТСАЙХАН |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ҮНДЭСНИЙ Г ХЭРЭГЖҮҮЛЭХЗорилго** | Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн дунд болон урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, татвар, хууль эрх зүйн орчинг тогтвортой байлгах, геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, Монгол улсын ашигт малтмалын сан хөмрөгийг арвижуулан баяжуулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг дээшлүүлэхэд оршино. | | | | | |
| **Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)** | Алтны олборлолтын хэмжээг тогтворжуулж, жилд дунджаар тогтвортойгоор 2-3 тонноор нэмэгдүүлнэ. /2020 онд алт олборлолтын хэмжээг 25 тн-д хүргэнэ./ | | | | | |
| **1. Үйл ажиллагааны чиглэл** | **Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл** Алтны сэдэвчилсэн судалгаа, хайгуулын ажлыг явуулах, алтны олборлолтын бүртгэлжүүлэлт, хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгох, үндсэн болон алт агуулсан бусад ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,боловсруулах тэргүүний техник технологи, менежмент нэвтрүүлэх, олборлолт хийгдсэн талбайг нөхөн сэргээх, алтны уурхайн хаалттай холбоотой үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, бичил уурхай эрхлэлтийг зохицуулах | | | | | |
| *Д/д* | *Үйл ажиллагаа* | *Бүтээгдэхүүн* | *Шалгуур үзүүлэлт* | *Хэрэгжилтийг хариуцах байгууллага* | *Хамтран хэрэгжүүлэх байгууллага* | *Хэрэгжих хугацаа* |
| **Татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх зорилт-1** | | | | | | |
| 1. | Алтны үйлдвэрлэлийн татварын орчин, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судалж, олон улсын чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх | - Алтны татвар, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлах,<br>- Нөхцлүүдийг тодорхойлох<br>- татвар, санхүүгийн нэмэлт өөрчлөлт оруулах хууль, дүрэм, журмын санал бэлтгэх<br>- Саналыг шийдвэрийн төсөл болгон боловсруулах<br>- Шийдвэрийн төслийг холбогдох байгууллагаар уламжлуулан шийдвэрлүүлэх | Холбогдох хууль, эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | УУХҮЯ, СЯ | АМГТГ, ТЕГ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2. | Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд<br><br>орон нутгаас тавьдаг шаардлагыг хуулийн хүрээнд тодорхой болгох, алтны үйлдвэрлэлийн салбарын хүрээнд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй болгох. | - Үйлчилгээг сайжруулах<br><br>-Нутгийн захиргааны байгууллагын оролцоо, шаардлагыг тодорхойлох,<br>- Байгаль орчин болон Мэргэжлийн хяналт, Ашигт малтмал, газрын тосны газрын оролцоо, шаардлага, үйлчилгээг тодорхойлох<br>- Төрийн байгууллагын хоорондын оролцоо, шаардлагыг тодорхойлох,<br>- Төрийн үйлчилгээний шуурхай байх зохистой хэлбэрийг тогтоох,<br>- Холбогдох хууль эрх зүйн үндэсийг бүрдүүлэх | Төрийн үйлчилгээг<br><br>шуурхай, чирэгдэлгүй болгосон байна.<br><br>Үйлчилгээг сайжруулах | УУХҮЯ<br>БОАЖЯ, | АМГТГ,<br><br>МХЕГ, ТЕГ, ЦЕГ, СХЗГ-ын ҮМСХГ, Орон нутгийн захиргаа | 2017-2018 |
| 3. | алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журмыг шинэчлэн боловсруулж мөрдөх; | -Алт олборлох, баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх, худалдах журмыг шинэчлэн боловсруулах,<br><br>-Журмуудыг батлуулах,<br><br>- Батлагдсан журмуудын хэрэгжилтийг хангах | Журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлсэн байна. | УУХҮЯ | АМГТГ, МХЕГ, Мэргэжлийн байгууллага, холбоод | 2017-2018 |
| 4. | алт олборлох болон баяжуулах, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах технологийн шаардлага, олборлолтын үеийн металл авалтын нормативт хязгаарыг тогтоож, холбогдох стандартыг боловсруулж мөрдүүлэх | - Алтны олборлолтт болон баяжуулалт, боловсруулалтын технологийн шаардлагын судалгааг хийх,<br>- олборлолтын үеийн металл авалтын нормативт хязгаарыг тогтоох судалгааг хийх,<br>- Судалгаанд үндэслэн стандарт боловсруулах | Холбогдох стандарт, журмыг боловсруулж мөрдүүлж эхэлнэ. | МХЕГ,<br><br>УУХҮЯ | АМГТГ, СХЗГ, ГТЛ, УУМХЗ, Мэргэжлийн байгууллага, холбоод, АМЭБХАТ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5. | алтны зах зээл дэх эрэлт, хэрэгцээ, үнийн дунд хугацааны төсөөллийг тодорхойлох, алтны олборлолт, борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөх | - Алтны зах зээлийн эрэлт, хэрэгцээ үнийн судалгаа, төсөөллийг урьдчилан гаргана.<br><br>Судалгаанд суурилан алтны борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөх<br><br>- | Алт олборлолт, борлуулалтаас орох төсвийн болон экспортын орлогыг оновчтой төлөвлөн, хэрэгжүүлсэн байна. | УУХҮЯ, ҮХГ | АМГТГ, СЯ, Монголбанк,ГЕГ, Монголын экспортлогчдын холбоо | 2017-2020 |
| 6. | алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, алт олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, олборлосон алтыг худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор зээл олгох ажлыг хэрэгжүүлэх, тогтвортой хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх | -Алт олборлогч аж ахуйн нэгжийн төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгааг нарийвчлан гаргана.<br>- Ойрын үед хэрэгжих боломжтой төслүүдийн жагсаалтыг гаргах<br>- Дунд хугацаанд хэрэгжих боломжтой төслүүдийн жагсаалыг гаргах | Алт олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, олборлосон алтыг худалдан авах нөхцлөөр зээл олгох ажлыг хэрэгжүүлсэн байна. | УУХҮЯ, СЯ, Монголбанк, Арилжааны банк, Хөгжлийн банк | АМГТГ, | 2017-2020 |
| 7. | алтны олборлолтын ажил төвлөрөн явагдаж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт бүхий бүсийг тогтоон алтны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг иж бүрэн цогцоор нь хэрэгжүүлэх | -<br><br>Алтны олборлолтыг дэмжих зорилгоор тусгай зориулалттай талбайн бүсийн судалгааг хийх<br><br>- Тусгай талбайг алт олборлолт төвлөрсөн Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Дорнод, Увс аймгийн нутгийн 5 бүсэд байгуулах<br><br>- Эдгээр онцгой талбайд орон нутаг, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны | Алт олборлолтын хэмжээг жилд 2 тн-с багагүй хэмжээгээр нэмэгдүүлнэ. Төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулна. | УУХҮЯ, БОАЖЯ | АМГТГ, МХЕГ, ЦЕГ, БХЯ, Орон нутгийн захиргаа, Монголбанк,СХЗГ-ын ҮМСХГ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хамгаалал, уурхайн хаалт, Монголбанк, Үнэт металлын сорьцын хяналтын газрын салбар, харуул хамгаалалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.<br><br>- Алт олборлолтыг нэмэгдүүлэх нөөц өсгөх, судалгааг гаргаж, хэрэгжүүлэх<br><br>Алт олборлолтыг нэмэгдүүлэх, нөөц өсгөх, нөөцийг бүрэн хаягдалгүй ашиглах, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг сайжруулах | | | | |
| 8. | хууль бусаар алт олборлохыг таслан зогсоохтой холбоотой эрх зүйн орчинг сайжруулах | “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхайн тухай хуулинд тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй болох нь уулын ажлын болон хайгуулын ажлын тайлан төлөвлөгөөгөөр тогтоогдсоныг үндэслэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох чиглэлээр тусгах<br><br>-Аймаг, сумын Засаг дарга болон хууль бусаар ашигт малтмал олборлогч этгээдэд | Хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо буурсан байна. | УУХҮЯ, МХЕГ | АМГТГ, ХЗДХЯ,<br><br>ЦЕГ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ноогдох хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох<br>-Хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа эрхлэгчдийн талаархи судалгааг нутаг дэвсгэрийн тархалт, ашиг орлого, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хийж тоог бууруулах | | | | |
| 9. | зэс болон бусад металлын баяжмал дахь үнэт металлыг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг татварын болон хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих | -Алт, зэс бусад металлын баяжмал дахь үнэт металл ялган авах боломжийн судалгааг боловсруулна.<br>-Баяжмал үйлдвэрлэн гаргаж байгаа аж ахуйн нэгжүүдийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулахад дэмжлэг үзүүлэх | Алт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулах нөхцлийг бүрдүүлсэн байна. | УУХҮЯ, | АМГТГ, СЯ, ТЕГ, Уул уурхайн өрсөлдөх чадвар, зах зээлийн хүрээлэн | 2017-2020 |
| 10 | "Алтны бирж" байгуулах боломжийг судлан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх | - Алтны бирж байгуулах судалгаа хийнэ.<br>- Судалгааг үндэслэн санал дүгнэлтийг гарган, холбогдох журмын төслийг боловсруулна. | "Алтны бирж" байгуулах боломжийг судлан хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. | УУХҮЯ, СЯ | АМГТГ, ҮХГ, Мэргэжлийн байгууллага, Монголын экспортлогчдын холбоо | 2017-2020 |
| 11 | алтыг орон нутагт худалдан авах үйл ажиллагааг Монголбанкны салбар буюу арилжааны банкаар гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх | - Алтыг орон нутагт худалдан авах үйл ажиллагааг судлан судалгааг гаргана. | Судалгааг гаргасан байна | Монголбанк, УУХҮЯ | АМГТГ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | - Судалгааг үндэслэж алт худалдан авах үйл ажиллагаа эхлүүлэх | | | | |
| 12 | бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх болон сорьц тогтоох үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмыг шинээр боловсруулан мөрдүүлэх | - Бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх болон сорьц тогтоох журмын судалгааг боловсруулна<br>- Судалгаанд суурилан холбогдох журмыг шинээр боловсруулна | Журмын төслийг боловсруулсан байна | УУХҮЯ, СЯ Монголбанк | АМГТГ, СХЗГ-ын ҮМСХГ, Тогтвортой бичил уурхай төсөл | 2017-2018 |
| **Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулах зорилт-2** | | | | | | |
| 1 | алтны хэтийн төлөв бүхий бүс, нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн болон алтны сэдэвчилсэн судалгаа, ерөнхий эрлийн ажлыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилийн улсын төсвийн төсөлд тусгуулан хэрэгжүүлэх | - Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн болон ерөнхий эрлийн ажлын төлөвлөгөөнд алтны сэдэвчилсэн судалгааны ажлыг явуулахаар тусгах<br>- Хэтийн төлөв бүхий талбайд сэдэвчилсэн судалгааны ажил явуулж үнэлгээ өгөх | Алтны сэдэвчилсэн судалгааны ажил хийгдэж нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөгдсөн байна. | УУХҮЯ, | АМГТГ, Мэргэжлийн байгууллага, шалгарсан ААН | 2017-2018 |
| 2. | алтжилт бүхий улсын өмнөд хил орчмын бүс, зарим тусгай хамгаалалттай газар нутагт геологийн судалгааг явуулж үнэлгээ өгөх, цаашдын чиглэлийг тодорхойлох | - Алтжилт бүхий улсын өмнөд хил орчмын бүс, зарим тусгай хамгаалалттай газар нутагт алтны тойм судалгааг хийх<br>- Тойм судалгааг үндэслэн зарим талбайнуудад эрэл үнэлгээний ажлыг хийх нөхцлийг бүрдүүлэх | Тойм судалгааг хийж үнэлгээ өгөгдсөн байна | УУХҮЯ, | АМГТГ, БХЯ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | алтны эрэл хайгуулын болон геологийн зураглалын ажилд олон улсад нэвтэрсэн тэргүүний дэвшилтэт техник, технологийг Монгол Улсад нутагшуулах, хайгуулын ажлын арга зүй, түүнд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх | - Алтны эрэл хайгуул, зураглалын ажилд олон улсын туршлагаар батлагдсан тэргүүний дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх судалгааг гаргана.<br><br>- хайгуулын ажлын арга зүй, түүнд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулах | Олон улсын туршлага, орчин үеийн техник технологийг нэвтрүүлсэн байна | УУХҮЯ, | АМГТГ, Мэргэжлийн байгууллага, холбоод | 2017-2020 |
| 4. | алтны хэтийн төлөв бүхий талбайд сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг тэргүүн ээлжинд зохион байгуулах | - Алтны хэтийн төлөв бүхий талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг үргэлжлүүлэн эхлүүлнэ<br><br>- Алтны тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд орон нутгаас тавьдаг шаардлагыг тодорхой болгох<br><br>- Хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгох сонгон шалгаруулалтын талбайг зарлахдаа алтны хэтийн төлөв сайтай илрэлийн талбайнуудыг тэргүүн ээлжинд олгодог болох | Журамд өөрчлөлт орсноор өргөдлөөр болон сонгоноор олгогдох эрэл хайгуулын тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлсэн байна | УУХҮЯ, | АМГТГ, БОАЖЯ, ОНЗ | 2017-2020 |
| 5. | алтны нөөцийн бүртгэл, эрэл хайгуулын ажлын мэдээллийг тогтмол шинэчлэн, нөөцийн хөдөлгөөнийг жил бүр хийж баталгаажуулах | - Алтны нөөцийн хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах:<br>- Алтны шороон ордуудын бүртгэл<br>- Алтны үндсэн ордуудын бүртгэл<br>- Алт агуулсан бусад металлын ордуудын бүртгэл | Алтны нөөцийн хөдөлгөөнийг тогтмол хийж, бүртгэлжүүлэлтийг сайжруулсан байна. | УУХҮЯ, | АМГТГ, МХЕГ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | - Алтны мэдээллийн санг бий болгож төрөлжүүлэх | | | | |
| **Алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник технологийг сайжруулж, шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх зорилт-3** | | | | | | |
| 1 | алтны олборлох үйл ажиллагаанд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, байгаль орчинд ээлтэй тэргүүний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | - Алтны үндсэн болон шороон ордуудад хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй тэргүүний дэвшилтэт техник технологийн судалгааг хийж, зөвлөмж боловсруулна.<br><br>- Тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Техник, технологи нэвтрүүлсэн байна. | МХЕГ, ОБЕГ, УУХҮЯ, | АМГТГ, Уул уурхайн хүрээлэн, Мэргэжлийн байгууллага, холбоод | 2017-2020 |
| 2. | хариуцлагатай ил тод уул уурхайг хөгжүүлэх, олон улсын туршлага, алтны эдийн засгийн үр өгөөж, орон нутгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмэр, алтны борлуулалтаас олох орлогын зарцуулалтын талаар олон нийтэд сурталчлан ойлгуулахад чиглэсэн мэдлэг, боловсрол олгох сургалт зохион байгуулах | - Төр, иргэд, олон нийтийн оролцоотойгоор хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх олон улсын туршлагыг судлах ажлыг өргөжүүлэх:<br>- Геологийн судалгааны шатанд<br>- Хайгуулын шатанд<br>- Олборлолтын үе шатанд<br><br>- Холбогдох сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна | Сургалтыг зохион байгуулсан байна. | УУХҮЯ, | АМГТГ, МАОЭНХ, УУҮА, УУМХЗ, ААН | 2017-2018 |
| 3. | ойролцоо болон хил залгаа орших тусгай зөвшөөрөл бүхий алтны ордуудын ашиглалтын үеийн тосгон, дэд бүтэц, зам, цахилгаан хангамж болон алт боловсруулах үйлдвэрийг | - Алтны ордууд болон бусад төрлийн ашигт малтмалын ордуудын дэд бүтэц, бүчилсэн хөгжилтэй уялдуулсан судалгааг боловсруулна. | Холбогдох судалгааг хийсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | УУХҮЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, ҮХГ | АМГТГ, Уул уурхайн хүрээлэн, УУМХЗ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | цогц байдлаар төлөвлөн байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх | - Алт боловсруулах үйлдвэрийг цогц байдлаар барьж байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх | | | | |
| 4. | стратегийн ач холбогдол бүхий алтны ордуудын ашиглалтыг эхлүүлэх | - Стратегийн ач холбогдол бүхий алтны ордуудыг ашиглах бэлтгэл ажлыг хангах<br>- Орд ашиглах гэрээг байгуулах<br>- Олборлолтын ажлыг эхлүүлэх | Ордуудыг ашиглах бэлтгэл ажлыг хангаж олборлолтыг эхлүүлсэн байна. | УУХҮЯ, | АМГТГ, СЯ төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж | 2017-2018 |
| 5. | алтны болон алт агуулсан бусад ашигт малтмалын ордуудад судалгаа хийж, үнэлгээ өгөх замаар эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай нөхцөлийг тодорхойлсны үндсэн дээр зохих дэмжлэг үзүүлэх | - Алтны болон алт агуулсан бусад ашигт малтмалын ордуудын судалгааг хийх<br>- Ойрын үед хэрэгжих боломжтой төслүүдийн судалгаа гаргах<br>- Ашиглалтад оролгүй хүлээгдэж байгаа ордуудын нөхцөл байдлын судалгаа гаргах<br>- Ордыг ашиглах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. Төлөвлөлтийн дагуу алт олборлолтыг 2018 онд 20 тн-д хүргэнэ. 2020 онд 25 тн-д хүргэнэ | Судалгааг гаргаж, аж ахуйн эргэлтэнд оруулах үнэлгээ хийгдсэн байна. | УУХҮЯ, | АМГТГ, Мэргэжлийн байгууллага, Мэргэжлийн холбоод, Алт олборлогч аж ахуй нэгж | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хууль”-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд шороон болон үндсэн ордуудын нөөцийг цаашид зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх | - Хуулийн хэрэгжилтэд хамрагдсан талбайн бодит судалгааг гаргаж холбогдох дүгнэлтийг гаргана.<br>- Хуулийн хэрэгжилтийг хангах зохистой шийдлийг гаргаж хэрэгжүүлнэ. | Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд шороон болон үндсэн ордуудын нөөцийг зохистой ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байна. | УУХҮЯ, БОАЖЯ | АМГТГ, | 2017-2018 |
| | | ойн сан бүхий газрын хилийн заагийг тухайн аймагт хийгдсэн хамгийн сүүлийн ойн зохион байгуулалтын зураглалаар тогтоож байх чиглэлээр асуудал боловсруулан ЗГ-т оруулах | Алтны зарим ордыг ашиглах, ойн сан бүхий газрыг бодитой тогтоох, хамгаалалтад авах арга хэмжээ хэрэгжсэн байна. | БОАЖЯ | БОАЖЯ | 2017-2018 |
| | | Гадаргын усны мэдээллийн санд өөрчлөлт оруулах Нөхөн сэргээсэн газрыг урсац бүрэлдэх эх, энгийн хамгаалалтын бүсэд буцаах чиглэлээр Засгийн газрын 2015 оны 120 тоот тогтоолоор баталсан "Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-д өөрчлөлт оруулах | Алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн бичиг баримтын бүрдэл хангагдаж нөхөн сэргээлтийг хийх эдийн засгийн хөшүүрэг бий болсон байна. | БОАЖЯ<br>УУХҮЯ | АМГ<br>БОАЖЯ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг тэмдэгжүүлэх, хамгаалах, үүссэн зөрчлийг арилгах арга хэмжээг тодорхойлж, аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг тэмдэгжүүлэх, хамгаалах, үүссэн зөрчлийг арилгах арга хэмжээ хэрэгжсэн байна. | УУХҮЯ<br>БОАЖЯ | МХЕГ<br>АМГ | 2017-2018 |
| 7 | Үнэт металлын сорьцын хяналтын байгууллагыг бэхжүүлж техник технологийг шинэчлэх, алт олборлолтын томоохон бүс нутагт сорьцын салбар лаборатори байгуулах нөхцөлийг хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах | - Стандарт, хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газрын лабораторийн техник технологийг шинэчлэх:<br>- Сорьцын лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх<br>Алт тушаалтын бүртгэлийг сайжруулах<br>- Алт олборлолтын томоохон бүс нутгуудад сорьцын лаборатори байгуулах нөхцөлийг бүрдүүлэх | Сорьцын хяналтын албын чадавхийг бэхжүүлж, техник технологийг шинэчилсэн байна. | СХЗГ-ын ҮМСХГ, СЯ, УУХҮЯ, Монгол банк, Мэргэжлийн байгууллага | АМГТГ, МХЕГ | 2017-2018 |
| 8 | алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулах | - Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах судалгааг гаргана<br>-Алт цэвэршүүлэх үйлдвэрийг барих ТЭЗҮ-ийн тооцоололыг боловсруулах<br>- Алт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. | Үйлдвэрийг байгуулсан байна. | УУХҮЯ, ҮХГ, Монголбанк | АМГТГ, Уул уурхайн өрсөлдөх чадвар, зах зээлийн хүрээлэн, Экспортлогчдын холбоо | 2017-2020 |
| 9 | алтыг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх | - Алтыг боловсруулах гар урлалын эцсийн бүтээгдэхүүн гаргах нарийвчилсан судалгааг гаргана. | Бүтээгдэхүүний төрөл, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн байна. | Монголбанк, СХЗГ-ын ҮМСХГ, ҮХГ | АМГТГ, Аж ахуйн нэгж, Тогтвортой | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | - Алтны сорьцын хяналтын үйл ажиллагааг сайжруулна<br><br>- Үнэт металлаар хийх уран дарханы гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих | | | бичил уурхай төсөл | |
| 10 | дэлхийн түвшний алтны олборлолт, худалдаа, олон улсын зах зээлийн үнэ, Монголбанкны сар бүрийн алтны худалдан авалтын тухай мэдээллийн нэгдсэн сан бий болгох | Дэлхийн түвшний алтны олборлолт, худалдаа, олон улсын зах зээлийн үнэ, Монголбанкны сар бүрийн алтны худалдан авалтын тухай мэдээллийн нэгдсэн сан бий болгох | мэдээллийн нэгдсэн санг бий болгосон байна | УУХҮЯ, Монголбанк | АМГТГ, СЯ, СХЗГ-ын ҮМСХГ, ТЕГ, ГЕГ | 2017-2018 |
| 11 | алтны олборлолт, боловсруулалт, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын үйл ажиллагааг стандартын түвшинд гүйцэтгэж, Монголбанкинд алт тушаасан үндэсний компанийн үйл ажиллагаанд зохих дэмжлэг үзүүлэх | - Монголбанкинд тушаасан алт, алтны олборлолтын судалгаа,<br>- Нөхөн сэргээлт, уурхайн хаалтын үйл ажиллагааны судалгаа хийх<br><br>- Тэдгээрийг урамшуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, холбогдох санал зөвлөмжийг гаргах | Үйл ажиллагааг дэмжиж урамшуулсан байна. | УУХҮЯ, БОАЖЯ | АМГТГ, МХЕГ, Орон нутгийн захиргааны байгууллага | 2017-2020 |
| 12 | алтны үйлдвэрлэлд ажиллагсдын чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа алт олборлогч аж ахуйн нэгж, ажиллах хүчний судалгааг хийж урамшууллын механизмыг бий болгох | - Алт үйлдвэрлэлд ажиллагсадын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулж байх<br><br>- Он удаан жил үр бүтээлтэй ажиллаж байгаа:<br>- алт олборлогч аж ахуйн нэгж ,<br>- албан хаагчдын судалгаа хийх,<br>- Тэдгээрийн хөдөлмөрийг | Сургалтыг зохион байгуулсан байна. Холбогдох судалгаа гаргаж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. | УУХҮЯ, Алт үйлдвэрлэгчдийн холбоо, УУМХЗ | АМГТГ, салбарын төрийн бус байгууллага, алт олборлогч аж ахуйн нэгж | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | үнэлэх, амжилт гаргасан байгууллага, хүмүүсийг урамшуулах ажлыг жил бүр зохион байгуулах | | | | |
| **Алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчинг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох зорилт-4** | | | | | | |
| 1 | алтны үйлдвэрлэлийн улмаас эвдрэлд орсон талбайн бүртгэл тооллого болон нарийвчилсан байр зүйн зураглал хийж, хохирлын хэмжээг тогтоосны үндсэн дээр нөхөн сэргээлт хийх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан буруутай хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх замаар алт олборлогч аж ахуйн нэгжийн хариуцлагыг өндөржүүлэх, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | - Алтны орд газрын эвдрэлд орсон талбайн судалгааг гаргана<br>- Нөхөн сэргээлт хийх талбайн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулна<br>- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх | Төлөвлөгөөг боловсруулж, нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.<br>Судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээллийн сантай болсон байна. | УУХҮЯ, БОАЖЯ | АМГТГ, МХЕГ, Орон нутгийн захиргааны байгууллага, Олон нийтийн зөвлөл | 2017-2018 |
| 2. | алт олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлж, тэдгээрт тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгох, төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх | - Алт олборлогчид, борлуулагчдын нэгдсэн судалгааг гаргах<br>- Алт олборлогчдыг бүртгэлжүүлэх<br>-Бүртгэлжүүлсний үндсэн дээр хяналтын тогтолцоог бий болгоно. Холбогдох журмыг боловсруулна | төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах нөхцлийг бүрдүүлсэн байна, холбогдох журмыг боловсруулсан байна. | УУХҮЯ, | АМГТГ, СЯ, СХЗГ-ын ҮМСХГ, Монголбанк | 2017-2018 |
| 3. | алтны орд ашигласны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн | - Олон улсын туршлагыг судалж зөвлөмж гаргана | Холбогдох аргачлалыг боловсруулж нэвтрүүлсэн байна. | УУХҮЯ, БОАЖЯ, ЭМЯ, МХЕГ | АМГТГ, Мэргэжлийн байгууллага | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээг тодорхойлох олон улсын туршлагыг судлан холбогдох аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх | - Зөвлөмжийн дагуу үнэлгээ тогтоох аргачлалыг боловсруулж нэвтрүүлнэ | | | | |
| | | Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх | Нөхөн сэргээлтийн ажлыг орхигдуулахгүй байх нөхцөл хэрэгжсэн байна. | УУХҮЯ<br>БОАЖЯ | АМГТГ<br>ЦЕГ<br>МХЕГ | 2017-2018 |
| | | Уул уурхайн хуулинд БОХ, НС үүргээ биелүүлээгүй болох нь уулын үйлдвэрийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд түтгэлзүүлэх, хүчингүй болгох чиглэлээр тусгах | БОХ, НС үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ илүү хатуу, хэрэгжих нөхцөл бүрдсэн болсон байна. | УУХҮЯ | УУХҮЯ<br>БОАЖЯ<br>ЦЕГ<br>МХЕГ | 2017-2018 |
| | | Алтны ордыг ашигласны улмаас байгаль орчинд учруулсан хохиролын үнэлгээг Төв,Сэлэнгэ, Баянхонгор, Архангай, Өвөрхангай зэрэг аймгуудын зарим суманд Мэргэжлийн байгууллаггар гүйцэтгүүлэх | байгаль орчинд учруулсан хохиролын үнэлгээ тодорхой болно. | БОАЖЯ | Аймгийн ЗД | 2017-2020 |
| 4. | хууль бусаар алтны олборлолт явуулсан талбайн бүртгэл хийж, холбогдох этгээдийг тогтоох ажлыг улсын хэмжээгээр эрх бүхий төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах | - Олборлолт хийсэн талбайн бүртгэлийн судалгаа хийх<br><br>- Олборлолт хийсэн этгээдийг тогтоох, бүртгэлийг хийх | Судалгаа, бүртгэл хийсэн байна. | ЦЕГ,<br>БОАЖЯ,<br>МХЕГ,<br>УУХҮЯ, | АМГТГ, | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5. | хууль бусаар алт олборлосон талбайд нөхөн сэргээлт, хаалт хийх нөхцөл бүрдүүлэх | - Хууль бусаар алт олборлосон, эзэн орхигдсон талбайн судалгааг гаргах<br>- Эдгээр талбайд нөхөн сэргээлт хаалт хийх нөхцлийг бүрдүүлэх | Нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлсэн байна. Хаалтын нөхцлийг бүрдүүлсэн байна. | УУХҮЯ, БОАЖЯ МХЕГ | АМГТГ, Орон нутгийн захиргаа | 2017-2020 |
| 6 | алтны үйлдвэрлэлийн улмаас тухайн уурхайн нөлөөллийн бүс нутгийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх, судлан хянах, тандах тогтолцоог бүрдүүлж алтны салбарт ажиллагсад, орон нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах | - Алтны уурхайн нөлөөллийн бүс нутагт байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөллийг үнэлэх, судалгааг хийх<br>- Алтны салбарт ажиллагсад, орон нутгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах | Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөллийг үнэлэх, судлах, хянах, тандах тогтолцоог эхлүүлсэн байна. | ЭМЯ , УУХҮЯ, БОАЖЯ | АМГТГ, Мэргэжлийн байгууллага, Орон нутгийн захиргаа | 2017-2020 |
| 7 | хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах | - Хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтын тогтолцооны судалгааг хийнэ<br>- Судалгааг үндэслэж, холбогдох журмын төслийг шинэчлэн боловсруулна | Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. | МХЕГ, ОБЕГ, УУХҮЯ, | АМГТГ, УУМХЗ, ҮЭБ, Мэргэжлийн байгууллага | 2017-2018 |
| 8 | уурхайн хаалтын хүрээнд алт олборлолтын онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох, алт олборлосны дараа уурхайн хаалт хийгдсэн талбайд хяналт, шалгалт хийх, талбайг орон нутагт хүлээлгэн өгөх үүрэг хариуцлагыг тодорхой болгох | - Уурхайн хаалтын зохицуулалтыг бий болгох<br>- Уурхайн хаалт хийгдсэн талбайд хяналт, шалгалт хийх,<br>- талбайг орон нутагт хүлээлгэн өгөх үүрэг хариуцлагыг тодорхой болгох | Уурхайн хаалт хийгдсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгөх үүрэг хариуцлагыг тодорхой болгосон байна. | УУХҮЯ, БОАЖЯ, МХЕГ | АМГТГ, Мэргэжлийн байгууллага, Орон нутгийн захиргаа | 2017-2020 |

| **Бичил уурхайгаар алт олборлоход ашиглаж байгаа техникийн стандартыг боловсронгуй болгох, хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах болон борлуулах албан ёсны сүлжээ бий болгох зорилт-5** | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | бичил уурхайгаар алт олборлоход ашиглаж байгаа техникийн стандартыг боловсронгуй болгох, хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авах болон борлуулах албан ёсны сүлжээ бий болгох | - Алтны бичил уурхай эрхлэлтийн судалгааг нарийвчлан гаргах<br>- Судалгаанд үндэслэж холбогдох журамд өөрчлөлт оруулах | алтны бичил уурхайд ашиглаж байгаа техникийн стандартыг сайжруулсан байна | УУХҮЯ | АМГТГ, Тогтвортой бичил уурхай төсөл Орон нутгийн захиргаа | 2017-2018 |
| 2 | бичил уурхай эрхлэх талбайг улсын хэмжээнд нарийвчлан тогтоож, бүртгэж байх | - Бичил уурхай эрхлэх талбайн судалгааг гаргах<br>- Судалгаанд үндэслэж талбайг тогтоох | Бичил уурхай эрхлэх талбайг тогтоосон байна. | УУХҮЯ, Мэргэжлийн байгууллага | АМГТГ , Орон нутгийн захиргаа | 2017-2018 |
| 3 | бичил уурхайгаар алт олборлогч иргэдийг албан ёсны болгох, нөхөрлөлийг чадавхижуулж бүртгэх замаар цаашид хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хүн амын орлогын болон бусад татвар, төлбөр, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох | - Бичил уурхай эрхлэгчдийн бүртгэл, олборлолтын талаарх судалгааг хийх<br>- Судалгааг үндэслэж татвар, хураамж ногдуулах оновчтой тогтолцоог бий болгох | нөхөрлөлийг чадавхижуулж аж ахуйн нэгж болгох ажлыг эхлүүлсэн байна. | УУХҮЯ, Орон нутгийн захиргаа | АМГТГ, СЯ, ТЕГ | 2017-2018 |
| 4 | алтны ордуудыг ашиглах явцад үүссэн хаягдал нөөцийг бүртгэлжүүлж, үнэлгээ хийх | -Үүсмэл ордын нөөцийг бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлнэ.<br>1.1 Үүсмэл ордын байршил, нөөцийн судалгааг гаргах<br>1.2 Үүсмэл орд ашиглах үнэлгээ хийх<br>- Үүсмэл орд ашиглах журмыг боловсруулна | Хаягдал нөөцийн судалгаа хийгдэж, нөөцийн үнэлгээ хийгдсэн байна. | УУХҮЯ, Мэргэжлийн байгууллага | АМГТГ , Орон нутгийн захиргаа | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | - Үүсмэл ордын нөөцийг тогтоох аргачлалыг боловсруулах | | | | |
| 5 | бичил уурхай эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник хангамж болон нөхөн сэргээлтийн талаар сургалт явуулах | - Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник хангамж болон нөхөн сэргээлтийн талаар сургалтыг улсын хэмжээнд явуулах.<br>- Сургалтыг тухайн орон нутагт явуулах | Тухай бүр сургалтыг явуулсан байна. | УУХҮЯ, МХЕГ, ОБЕГ, Мэргэжлийн холбоод | АМГТГ, Орон нутгийн захиргаа, Тогтвортой бичил уурхай төсөл | 2017-2018 |
| 6 | тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж орхигдсон талбайд байгаа үүсмэл ордуудыг ашиглах үйл ажиллагаанд орон нутгийн нөхөрлөлийг оролцуулахад дэмжлэг үзүүлэх | - Талбайн судалгааг хийж үүсмэл ордын хэсгийг бүртгэх<br>- Бүртгэсэн талбайд нөхөрлөл оруулах асуудлыг шийдвэрлэх | Үүсмэл ордыг ашиглахад хаягдал багатай ашиглах технологийг нэвтрүүлсэн байна. | УУХҮЯ, | АМГТГ, Орон нутгийн захиргаа, Тогтвортой бичил уурхай төсөл | 2017-2018 |